



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2011 он

**Энэхүү эмхтгэлийн талаархи саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.
Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг-Эрүүл Мэндийн Газар**

Шуудангийн хаяг: С.Зоригийн гудамж
Улаанбаатар -210648
Факс: 976-11-320633
Утас: 70111485, 325540
Э-шуудан: admin@doh.gov.mn
www.doh.gov.mn

Редактор: Ш.Энхбат, ЗГХА-ЭМГазрын дарга
/Анагаахын шинжлэх ухааны доктор/

Эмхтгэсэн: С.Ариунтуяа, ЭМСХ-ийн дарга
/НЭМ-ийн магистр/
Х.Нарантуяа, ЭМСХ-ийн мэргэжилтэн
/Удирдахуйн ухааны магистр/
С.Даваажаргал, ЭМСХ-ийн мэргэжилтэн
Т.Энхжаргал, ЭМСХ-ийн мэргэжилтэн
Т.Өнөрцэцэг, ЭТТЭЗХ-ийн мэргэжилтэн

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Уранчимэг
Д.Алтанцэцэг

Хэвлэлийн дизайнер: Н.Нямдорж

Товчилсон нэр томъёоны тайлбар

АР	Архангай
БӨ	Баян-Өлгий
БХ	Баянхонгор
БУ	Булган
ГА	Говь-Алтай
ГС	Говьсүмбэр
ДА	Дархан-Уул
ДГ	Дорноговь
ДО	Дорнод
ДУ	Дундговь
ЗА	Завхан
ОР	Орхон
ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
ТӨ	Төв
УВ	Увс
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
АД	Аймгийн дүн
УБ	Улаанбаатар
УД	Улсын дүн
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
МХЗ	Мянганы хөгжлийн зорилт
ӨОУА	Өвчний олон улсын ангилал
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ДОХ	Дархлалын олдмол хамшинж
ДОТС	Богино хугацааны шууд хяналттай эмчилгээ
СТДХ	Сүрьеэтэй тэмцэх дэд хөтөлбөр
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
ЖСА	Жирэмслэлтээс сэргийлэх арга
ХӨЦМ	Хүүхдийн өвчний цогц менежмент
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ОХУ	Оросын холбооны улс

ӨМНӨХ ҮГ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газрын статистикийн хэлтсээс 1970 оноос эхлэн эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ тайланд тулгуурлан жил бүр эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийг олон улсын аргачлалын дагуу боловсруулан, дүгнэлт үнэлгээ өгч эмхэтгэл хэлбэрээр хэвлүүлж та бүхэнд хүргэдэг билээ.

2011 оны энэхүү эмхэтгэл нь Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтын эрүүл мэндийн үзүүлэлтүүд болон салбарын үндсэн үзүүлэлтүүд, хүн ам зүй, хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаануудыг бүс нутаг, хот хөдөө, хүйс, насны бүлэг, эмнэлгийн тусламж үйлчилгээний байгууллагуудаар гаргаж, эрүүл мэндийн эдийн засаг, үндэсний хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүдийг тооцон нэгтгэсэн бөгөөд дэлхийн болон ДЭМБ-ын бүсийн орнуудын эрүүл мэндийн салбарын үндсэн үзүүлэлт, дэлхийн хүн амын нас баралтын төлөв байдалтай харьцуулан дүгнэлт хийсэн нотолгоонуудыг оруулж, нийт 86 хүснэгт, 69 зураг, 44 газар зүйн байршлын дүрслэлээр илэрхийлэн та бүхний хүртээл болгож байна. Үндэсний хэмжээний яаралтай тусламж үйлчилгээний үзүүлэлт болон мэс заслын эмчилгээний талаарх мэдээллийг өргөжүүлэн оруулсан нь шинэлэг зүйл болсон.

Эрүүл мэндийн яамнаас 2011 оныг “Нийгмийн эрүүл мэнд-нийтийн биеийн тамир”-ын жил болгон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүн зэрэгт тавьж, “Урьдчилан сэргийлэх нь эмчлэхээс хялбар”, “Эрүүл эхээс эрүүл хүүхэд” гэсэн стратеги бодлогын хүрээнд эрүүл мэндийн салбарын 90 жилийн ойн түүхэн жилийг тэмдэглэсэн онцлогтой.

Монгол улс 2015 онд дэвшүүлсэн Мянганы хөгжлийн зорилтуудыг хангаж, 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 2011 онд 48.2 болж, нялхсын эндэгдэл өмнөх онуудтай харьцуулахад хамгийн бага түвшинд хүрсэнийг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Эрүүл мэндийн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид болон мэдээлэл хэрэглэгч нийт хүмүүст нотолгоонд тулгуурласан оновчтой шийдвэр гаргахад бидний энэхүү эмхэтгэл дэмжлэг үзүүлнэ гэдэгт бүрэн итгэлтэй байна.

ДАРГА



Ш.ЭНХБАТ

Гарчиг

Бүлэг 1. Монгол Улсын хүн ам	6 - 9
1.1. Хүн ам	6
1.2. Дундаж наслалт, нас, хүйсийн суварга	7
1.3. Хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд	8-9
Бүлэг 2. Мянганы хөгжлийн эрүүл мэндийн зорилтууд	10 -14
Бүлэг 3. Эх хүүхдийн эрүүл мэнд	15 - 26
3.1. Эхийн эрүүл мэнд	15-16
3.2. Жирэмсний үеийн буюу төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ	16-17
3.3. Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ	18-19
3.4. Төрсний дараах тусламж, үйлчилгээ	20
3.5. Эхийн эндэгдэл	21-22
3.6. Хүүхдийн эрүүл мэнд ба хөхөөр хооллолт	22-23
3.7. Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	23-25
3.8. Үр хөндөлт	26
3.9. Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээ /ЖСА/	26
3.10. Үргүйдэл	26
Бүлэг 4. Эмнэлгийн тусламж үйлчилгээ	27-40
4.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ	27-29
4.2. Сумын эрүүл мэндийн төвийн болон сум дундын эмнэлгийн тусламж, үйлчилгээ	29-31
4.3. Нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ	31-33
4.4. Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн тусламж, үйлчилгээ	34-35
4.5. Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвийн тусламж, үйлчилгээ	35-37
4.6. Хувийн хэвшлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ	37-38
4.7. Түргэн тусламжийн үндэсний сүлжээний төвийн алсын дуудлагын үйл ажиллагаа	39-40
Бүлэг 5. Эрүүл мэндийн салбарын хүний нөөц	41-44
2010-2011 онд эрүүл мэндийн салбарт хийгдсэн судалгааны ажлууд (Жагсаалт)	44
Бүлэг 6. Халдварт өвчин	45-52
6.1. Нийт халдварт өвчин	45
6.2. Гэдэсний халдвар	45
6.3. Амьсгалын замын цочмог халдвар	48-51
6.4. Бэлгийн замаар дамжих халдвар	51-52
Бүлэг 7. Халдварт бус өвчлөл	53-58
7.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан	53-57
7.2. Мэс заслын үйл ажиллагаа	58
Бүлэг 8. Хүн амын нас баралт	59-63
8.1. Зүрх-судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт	60-61
8.2. Хорт хавдрын шалтгаант нас баралт	61
8.3. Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан	62-63
Бүлэг 9. Монгол улсын эмийн бүртгэлийн талаар	64-65
Бүлэг 10. Эрүүл мэндийн эдийн засаг	66-73
10.1. Эрүүл мэндийн салбарын санхүүжилт	66-69
10.2. Эрүүл мэндийн даатгал	68-71
Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй НЭМ-ийн хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтүүд	72-78
Бүлэг 11. ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн мэдээний санд орох Монгол улсын үзүүлэлтүүд, 2011	79-83
Бүлэг 12. Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүд, /хүснэгтээр/	84 -121
Бүлэг 13. Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүд, /газар зүйн байршлаар/	122-131

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ

1.1. Хүн ам

Монгол улс нь засаг захиргааны нэгжийн хувьд нийслэл, аймагт, аймаг нь суманд, сум нь багт хуваагдана. Өнөөдрийн байдлаар Монгол улс нь 21 аймаг, 329 сум, 1578 багтай. Улаанбаатар хот нь Монгол улсын нийслэл бөгөөд 9 дүүрэг, 152 хороодод хуваагдаж байна.


Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээ 1564.1 мян.км, хүн амын нягтшил нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүний тоо 1.81 байна.

2011 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын хүн амын тоо 2 сая 811.6 мянга болж, өмнөх оныхоос 30.9 мян.хүн буюу 1.1 хувиар өслөө. Нийт хүн амын 67.1 хувь нь хот суурин газар, үлдсэн 32.9 хувь нь хөдөө амьдарч байна. Хүн амын 48.6 хувийг эрэгтэйчүүд, 51.4 хувийг эмэгтэйчүүд, насны бүтцээр авч үзвэл 15 хүртэлх насны хүүхэд 27.2 хувийг, 15- 64 насны хүн ам 68.8 хувийг, 65 дээш насны хүн ам 4.0 хувийг тус тус эзэлж байна.


Улаанбаатар хот 1265.7 мянган хүн амтай болсон ба нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт ногдох хүний тоо 2011 оны байдлаар 274 болж, 2010 оныхоос 9 хүн буюу /3.4 хувиар/ нэмэгджээ.

2010 оны хүн амын тооллогоор нийт өрхийн тоо 2000 оныхоос 31.9 хувиар өссөний дотор хотын өрх 61.8 хувиар өсч, харин хөдөөгийн өрх 4.3 хувиар буурсан байна гэсэн дүгнэлт гарчээ. 1990 оноос хойш хотжилт, нийгэм эдийн засгийн хөгжлөө даган хүн ам төв суурин газар руу шилжих хөдөлгөөн буурахгүй байгаагаас 2000 онд нийт хүн амын 42.8 хувь нь хөдөөд оршин суудаг байсан бол 2011 онд 32.9 хувь болж буурсан байна. Энэ үзүүлэлт 2010 онд 36.7 байсан бол 1 жилийн дотор 3.8 пунктээр буюу хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн хувь нэмэгдсээр байна. 2011 онд нийт хүн амын 43.1 хувь нь УБ хотод, 24.0 хувь нь аймгийн төвд үлдсэн 32.9 хувь нь хөдөө буюу сумын төв, багт амьдарч байна.

Зураг 1.1.1. 2011 оны хот, хөдөөгийн хүн амын тоо, аймгаар



Зураг 1.1.2. 2011 оны дундаж хүн амын тоо, аймгаар



Улсын хэмжээнд 2011 оны байдлаар 759.9 мян өрх, түүний 63.6 хувь нь хотод, 36.4 хувь нь хөдөөд байгаа бөгөөд улсын дунджаар нэг өрхөд 3.7 хүн ногдож байна.

1.2 Дундаж наслалт, нас, хүйсийн суварга


Хүний хөгжлийн индексийн үндсэн үзүүлэлтийн нэг болох хүн амын дундаж наслалтаараа Монгол улс хүний хөгжлийн дунд зэргийн хөгжилтэй оронд багтдаг бөгөөд 2011 оны байдлаар хүн амын дундаж наслалт 68.32 байна. Хүйсээр авч үзэхэд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 73.76, эрэгтэйчүүдийнх 64.68 болсон байна. 2011 оны байдлаар дэлхийн улс орнуудын хүн амын дундаж наслалттай харьцуулахад Монгол улс 153-т бичигдсэн байна.

Хүснэгт 1.1.1. Хүн амын дундаж наслалт дэлхийн зарим улс орнуудаар, 2011 он

Жагсаалт	Улс/хот	Дундаж наслалт	Мэдээлэл тавигдсан хугацаа
1	Монако	89.7	2011 он
2	Макао	84.4	2011 он
3	Сан-Марино	83.0	2011 он
4	Андора	82.4	2011 он
5	Япон	82.3	2011 он
6	Сингапур	82.1	2011 он
7	Гонг Конг	82.0	2011 он
8	Австрали	81.8	2011 он
9	Итали	81.8	2011 он
10	Жерсей		
11	Канад	81.4	2011 он
12	Франц	81.2	2011 он
13	Испани	81.2	2011 он
14	Швейцари	81.1	2011 он
153	Монгол	68.3	2011 он
154	Белиз	68.2	2011 он
155	Тимор	68.0	2011 он
156	Боливия	67.6	2011 он

Монгол улсын хүн амын дийлэнх хувийг залуучууд эзэлж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд төрөлт, төрөлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотойгоор сүүлийн 10 жилд хүн амын нас, хүйсийн бүтцэд гарсан өөрчлөлтийг 2001, 2011 оны хүн амын суваргаас харж болно.

Зураг 1.1.3. Нас хүйсийн суварга, /2001, 2011/



1.3. Хүн ам зүйн зарим үзүүлэлтүүд

Монгол улс сүүлийн арваад жилд хүн амын эрүүл мэндийг сайжруулах тал дээр тогтвортой амжилт гаргаж байна. 1990 оноос хойш хүн ам зүйн байдал шилжилтийн үед байсан бөгөөд энэ нь төрөлт, нас баралтын түвшин огцом буурч, хүн ам хөгшрөх байдлаар тодорхойлогдож байсан. Тухайлбал 1990 онд манай улсын хүн амын дундаж өсөлт 2.7 хувь байсан бол 2000 онд 1.4 хувь, 2003-2005 онд 1.2 болон буурсан хэдий ч 2007-2009 онд хүн амын өсөлт 1.5-2.0 болж өмнөх 3 жилтэй харьцуулахад 0.3-0.8 хувиар нэмэгдсэн байна. 2011 оны байдлаар хүн амын цэвэр өсөлт 1.9 болсон байна.

Түүнчлэн 1990 онд 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 35.3 байсан бол 2003 гэхэд 18.0 болж 2 дахин буурч, 2007 оноос тогтворжин 21.7 болж 1000 хүн ам тутамд жил бүр 1.6-2 төрөлтөөр нэмэгджээ. 2011 оны байдлаар энэ үзүүлэлт 25.3 болон нэмэгдсэн байна.

Нэг эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлэх хүүхдийн тоо 1990 онд 4.3 байсан бол 2000-2003 онд гэхэд 2 дахин буурч, 2010 онд 2.3 байсан бөгөөд 2011 оны байдлаар 2.6 болон нэмэгдсэн байна.

2011 онд 70576 хүүхэд амьд төрснөөс 2 ихэр хүүхэд 1480 /740 төрөлт/, 3 ихэр хүүхэд 12 /4 төрөлт/ байна. Амьд төрсөн хүүхдийн 51.4 хувь нь эрэгтэй, 48.6 хувь нь эмэгтэй хүүхэд байгаа бөгөөд төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охидод 104,1 байна.

Хүснэгт 1.3.1. Хүн ам зүйн үзүүлэлтүүд, сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Нийт хүн (мян)	2149.2	2407.5	2562.3	2594.8	2626.6	2683.5	2735.5	2780.7	2811.6
Хотын хүн ам (хувиар)	54.6	57.2	60.2	60.9	61.0	61.4	62.6	63.3	67.1
Хөдөөгийн хүн ам (хувиар)	45.4	42.8	39.8	39.1	39.8	38.6	37.4	36.7	32.9
Насны бүлгээр (хувиар)									
0-15	41.5	33.7	32.6	28.6	28.9	28.1	27.6	27.3	27.2
15-64	54.4	62.8	63.9	67.3	67.3	67.8	68.4	68.8	68.8
65 аас дээш	4.1	3.5	3.5	4.1	4.1	4.1	4.0	3.9	4.0
Хүн ам зүйн коэффициентууд									
ТЕК	35.3	21.5	17.8	18.4	21.7	23.7	25.3	23.8	25.3
НЕК	7.9	5.9	6.1	6.1	6.2	5.7	5.7	6.3	6.2
Цэвэр өсөлт	2.7	1.5	1.17	1.23	1.55	1.8	1.9	1.7	1.9
ТНК	4.3	2.2	1.9	1.9	2.3	2.6	2.8	2.4	2.6

2000 оны хүн амын тооллогын дүнг үндэслэн 2025 онд өндөр настны тоо 2005 онд 2000 оныхоос 16.2 хувиар буюу 20.1 мянган хүнээр, 2010 онд 2000 оныхоос 28.7 хувь буюу 35.6 мянган хүнээр өснө гэсэн тооцоо гарсан байна.

2010 оны тооллогын нэгдсэн дүгнэлтээс үзэхэд Монгол Улсын хүн амын жилийн дундаж өсөлт 2000-2010 онд 1.5 хувь болсон нь өмнөх 10 жилийнхээс өссөн үзүүлэлттэй байна.

Аймгуудын хүн амын жилийн дундаж өсөлт дотоод шилжих хөдөлгөөний нөлөөгөөр Дорноговь, Өмнөговь, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр, нийслэлд өсч бусад аймагт буурчээ. Сүүлийн 20 жилд хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд тийм ч өндөр байсангүй. Цаашдаа хүн амын тоо энэ хэмжээгээр өсвөл ойролцоогоор 50 жилийн дотор одоогийнхоос 2 дахин олон болох магадлалтай байна.

Нийт хүн амд 0-4 насныхны эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс өссөн байна. Энэ нь өнгөрсөн 10 жилд нийтдээ 583.8 мянган хүүхэд төрсний дотор 2007-2009 онуудад төрөлт өмнөх жилүүдийнхээс тогтвортой нэмэгдэж, 2010-2011 онуудад 2009 онтой харьцуулахад 1.5 промилль-оор нэмэгдсэн нь хүн амын өсөлтөд эерэг нөлөөлсөнтэй холбоотой юм.

Харин 5-9 насны бүлэг дэх хувийн жин өмнөх 10 жилийнхээс буурсан байна. Ерөнхийдөө 0-14 насны хүүхдүүдийн эзлэх хувийн жин 2000 оныхоос 8.5 пунктээр буурсан бол хөдөлмөрийн буюу 15-64 насны хүн амын хувийн жин 8.3 пунктээр нэмэгдэж, хөдөлмөрийн насны хүн амд ногдох тэжээлгэгчдийн харьцаа буюу хүн ам зүйн ачаалал 2010 онд 2000 оныхоос 19.6 пунктээр буурсан дүгнэлт гарсан байна.

БҮЛЭГ 2. МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗОРИЛТУУД

МХЗ-ыг 2000 оны 9 сард Дэлхийн Мянганы Дээд Хэмжээний Чуулга уулзалтад оролцсон дэлхийн 191 үндэстнийг төлөөлсөн 147 орны төр засгийн тэргүүнүүд баталж, тогтвортой хөгжил, ядууралтай тэмцэх асуудлыг дэлхийн хөгжлийн тэргүүлэх чиглэлээр сонгосноор мянганы хөгжлийн зорилтууд нь аль ч улс орны хөгжил дэвшлийг хэмжих хэмжүүр болж байна.

Монгол улс 2008 онд үндэснийхээ МХЗ-уудыг өргөжүүлэн баяжуулж, хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх асуудлыг МХЗ-уудынхаа салшгүй хэсэг болгож, нийт 9 зорилго, 24 зорилтуудыг дэвшүүлэн УИХ-аар батлуулан, биелэлтийг хангахын тулд зохих арга хэмжээ, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Монгол улсын МХЗ-ын хүрээнд хүүхдийн эндэгдлийг бууруулах, эхийн эрүүл мэндийг сайжруулах, ХДХВ/ДОХ, сүрьеэ өвчинтэй тэмцэх гэсэн эрүүл мэндийн 3 зорилго, /9-13 зорилтууд хамаарна/ дэвшүүлсэн байдаг.

Зорилт 9

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах

Хүснэгт 2.1.1. Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2015
Нялхсын эндэгдэл /1000 амьд төрөлтөд/										
Хүйс										
Эрэгтэй	-	-	22.8	22.1	19.2	22.4	22.6	21.3	17.5	
Эмэгтэй	-	-	18.6	17.3	16.4	16.6	17.6	17.3	15.1	
Байршил										
Улсын дундаж	63.4	31.2	20.8	19.8	17.8	19.6	20.2	19.4	16.3	22.0 ^а /15.0 ^б
УБ хот	70.3	32.8	18.1	19.0	14.7	17.5	18.0	16.1	13.3	-
Аймгийн дундаж	62.5	30.8	22.5	20.3	20.3	21.2	21.9	22.1	19.2	-
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/										
Хүйс										
Эрэгтэй	-	-	28.4	26.8	23.3	26.4	25.9	26.4	21.9	
Эмэгтэй	-	-	23.6	21.1	20.8	20.2	21.2	22.7	18.0	
Байршил										
Улсын дундаж	87.5	42.4	26.1	24.0	22.1	23.4	23.6	24.6	20.0	29.2 ^а /21.0 ^б
УБ хот	99.9	42.4	21.7	21.8	18.8	20.8	21.0	20.6	16.2	-
Аймгийн дундаж	94.4	42.5	28.9	25.6	24.6	25.3	25.7	28.0	23.5	-

Эх үүсвэр: а. УИХ-ын тогтоол #15 Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2005
б. УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

Сүүлийн 20 жилийн хугацаанд нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин тогтвортой буурсныг дээрх статистик тоо мэдээллүүд нотлон харуулж байна. Энэ бууралт нь өргөн дархлаажуулалт, хүүхдийн өвчний цогц менежмент, хөхөөр хооллолтыг дэмжих зэрэг нийгмийн эрүүл мэндийн оновчтой арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлж байгаатай холбоотой юм.

2015 онд хүрэх зорилтын хэрэгжилтийн түвшин

1990 онд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 87.5, нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 63.4 байсан бол 2006 онд энэ үзүүлэлт 24.0 болон 19.8 болж 2015 онд хүрэхээр тавьсан зорилтоо хангасан тул 2008 онд Засгийн Газраас хүрсэн амжилтаа бататгахын тулд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 21.0, нялхсын эндэгдлийг 15.0-д хүргэх шинэ зорилтуудыг дэвшүүлсэн юм.

1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 онд 87.5 байсан бол 2007 он гэхэд 4 дахин буурч 22.1 болсон бол, 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 64.4 байсан бол 2007 онд 17.8 болж 3.6 дахин буурсан байна. Ийнхүү нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 оноос хойшхи 20 жилийн хугацаанд эрчимтэй буурчээ.

2011 оны байдлаар 1000 амьд төрөлтөд ногдох нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 16.3, тав хүртэлх насандаа эндсэн хүүхдийн эндэгдлийн түвшин 20.0 болсон ба энэ үзүүлэлтийг 2015 онд хүрэх зорилтын түвшин аймгуудын дунд ялгаатай байгаа юм.

Хүснэгт 2.1.2. 2015 онд дэвшүүлсэн зорилтыг хангасан байдал, аймгуудаар, 2011

2015 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт түвшин	Нялхсын эндэгдлийн түвшин, аймгаар	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, аймгаар
Хүрсэн	(7 аймаг + 1 хот)	(8 аймаг + 1 хот)
(>15.0) ^а (>21.0) ^б	Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Орхон, Сэлэнгэ, Улаанбаатар хот	Архангай, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Орхон, Сэлэнгэ, Улаанбаатар хот
Боломжтой	(7 аймаг)	(6 аймаг)
(15.0-20.9) ^а (21.0-25.9) ^б	Архангай, Баянхонгор, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хэнтий	Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Ховд
Удаан	(4 аймаг)	(5 аймаг)
(21.0-25.9) ^а (27.0-32.0) ^б	Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс	Баян-Өлгий, Завхан, Төв, Увс, Хэнтий
Боломжгүй	(3 аймаг)	(2 аймаг)
(26.0<) ^а (32.0<) ^б	Өвөрхангай, Төв, Хөвсгөл	Өвөрхангай, Хөвсгөл

Тайлбар: а. Нялхсын эндэгдлийн түвшин
б. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин

Нялхсын эндэгдэл буурахын хирээр нийт эндэгдлийн дотор нярайн эндэгдлийн эзлэх хувь нэмэгддэг байна. Нярайн эндэгдэл нь жирэмсэн эхийн эрүүл мэнд, төрөх үеийн хүндрэлтэй ихээхэн холбоотой байдаг.

Нялхсын эндэгдлийн шалтгаанд перинаталь үед үүссэн зарим эмгэг, амьсгалын тогтолцооны өвчин, төрөлхийн гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг, өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан, хоол боловсруулах тогтолцооны өвчний шалтгаант эндэгдэл тэргүүлж байгаа ба сүүлийн жилүүдэд төрөлхийн гажгийн эндэгдэл нэмэгдсээр байна.

Зорилт 10

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд дөрөв дахин бууруулах талаар

Монгол улс эхийн эндэгдлийн түвшингээр бүсийн болон өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад дунд зэргийн оронд багтдаг билээ. Эхийн эндэгдлийг тогтвортой бууруулах талаар засгийн газраас ихээхэн анхаардаг төдийгүй энэ талаар хэрэгжүүлдэг хөтөлбөр, төсөл, тушаал журмууд амжилттай хэрэгжсээр байна. 2011 онд хуралдсан “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний V бага хуралд Монгол улс эхийн эндэгдлийг бууруулах 2 удаагийн стратегийг амжилттай хэрэгжүүлсний дүнд эх хүүхдийн эрүүл мэндийн олон үзүүлэлтүүд сайжирсаныг цохон тэмдэглэсэн билээ.

Хүснэгт 2.1.3. Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлтөд), сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2015
Улсын дундаж	199.0	158.5	93.0	69.7	89.6	49.0	81.4	45.5	48.2	50.0 ^a
УБ хот	126	171.1	73.3	71.8	73.7	55.2	78.9	46.2	44.2	-
Аймгийн дундаж	230	153.4	105.7	68.2	102.0	44.3	83.5	44.9	51.8	-

Эх үүсвэр: а.УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

Эхийн эндэгдэл сүүлийн 5 жилд тогтвортой буурч 1990 онтой харьцуулахад 2.4-4.4 дахин буурсан нь Мянганы хөгжлийн зорилтыг хангаад байгаа билээ. 2011 онд эхийн эндэгдлийн нийт 34 тохиолдол бүртгэгдэж 100 000 амьд төрөлтөд 48.2 болсон байна. Монгол улсын засгийн газраас Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний 3 дахь хөтөлбөрийг 2007-2011 онд үргэжлүүлэн хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд эхийн эндэгдлийн түвшин ийнхүү тогтвортой буурсаар байна.

Эхийн эндэгдэл хөдөө орон нутаг, аймаг, бүсүүдэд ялгаатай байгаа нь тусламж үйлчилгээ болон хүний нөөц, эх нярайн өвчлөл, хүндрэлийг эрт оношлох багаж тоног төхөөрөмж дутагдалтай байгааг харуулж байна. Алсагдсан баруун бүс нутгуудад эхийн эндэгдлийн түвшин 100 000 амьд төрөлтөд 62.5 байгаа нь бусад бүс нутаг, улс, аймгийн дунджаас өндөр байна.

Зорилт 11

2015 он гэхэд ХДХВ/ДОХ өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар

Манай улсын нийт хүн амын дундах Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ), дархлалын олдмол хомсдол (ДОХ)-ын тархалтын түвшин 1.0 хувиас бага байгаа бөгөөд зүүн Ази, Номхон далайн бусад зарим орнуудтай харьцуулбал ХДХВ, ДОХ-ын тархалт багатай 5 улс орны тоонд багтдаг хэдий ч ХДХВ-ын бүртгэгдсэн тохиолдол сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байна.

Хүснэгт 2.1.4. Жирэмсэн эмэгтэйчүүд болон 15-24 насны залуучуудын дундах ХДХВ-ын тархалт, хувиар

Шалгуур үзүүлэлт	1990	2000	2006	2007	2008	2009	2010	2011	2015
Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах ХДХВ-ын халдварын тархалт	-	-	0.004	0.001	0.0	<0.1	<0.1	<0.1	<0.1 ^a
15-24 насны залуучуудын дундах ХДХВ-ын халдварын тархалт	-	-		0.0007	0.0005	<0.1	<0.1	<0.1	<0.1

Эх үүсвэр: а.УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

1992 онд Монгол улсад анхны ХДХВ/ДОХ-ын тохиолдол бүртгэгдсэнээс хойш 2011 оны жилийн эцсийн байдлаар ХДХВ/ДОХ-ын нийт 100 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 17 тохиолдол нь 2011 онд шинээр бүртгэгдлээ. Бүртгэгдсэн 100 тохиолдлын 15 нь нас барсан байна. 1992-2004 онд дунджаар ХДХВ/ДОХ-ын 1 тохиолдол, 2005-2010 онд 9-21 тохиолдол бүртгэгдэж байсан бол 2011 онд ХДХВ/ДОХ-ын 17 тохиолдол бүртгэгдлээ.

2011 онд бүртгэгдсэн ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн 14 (82.3%) нь эрэгтэйчүүд, 3 (17.6%) нь эмэгтэйчүүд байна. ХДХВ-ийн халдвартай гэж бүртгэгдсэн тохиолдлууд 100 хувь бэлгийн замаар халдвар авсан байна. Насны бүлгээр авч үзвэл: 17.6 хувь буюу 3 тохиолдол 15-24 насны өсвөр, идэр насны залуучууд, 52.9 хувь буюу 9 тохиолдол нь гэр бүлгүй хүмүүсийн дунд бүртгэгдсэн нь цаашид ХДХВ-ийн халдвар нэмэгдэх магадлалыг нэмэгдүүлж байна. ХДХВ-ийн халдварын 3 (17.6%) тохиолдол нь идэвхтэй тандалтаар, 14 (82.3%) тохиолдол нь өвчний улмаас эмнэлэгт хандсан болон хэвтэн эмчлүүлж буй хүмүүсээс илэрчээ. Ретровирусын эсрэг эмчилгээнд 2011 оны шинэ тохиолдлоос 6 өвчтөн хамрагдсан ба тухайн онд 3 жирэмсэн байснаас 2 нь төрсөн байна.

Зорилт 12**2015 онд гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах талаар**

Сүрьеэ өвчин нь улс орны нийгэм, эдийн засгийн байдал, хүн амын амьжиргааны түвшинтэй шууд хамааралтай байдаг. Манай орны хувьд 1990-ээд оноос эхэлсэн нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн үр дагаврууд болох инфляци, ажилгүйдэл, ядуурал, шилжилт хөдөлгөөн зэрэг нь уг өвчний тархалтад нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд сүрьеэ өвчний илрүүлэлт, эмчилгээний чанар сайжирч, нас баралтын түвшин буурч байгаа боловч өвчлөлийн түвшин нэмэгдэж байгаа нь тавьсан зорилтыг хангахад бэрхшээлтэй болж байна. ДЭМБ-ын судалгаагаар Номхон Далайн Баруун Эргийн бүсэд багтдаг сүрьеэгийн өвчлөл өндөртэй 7 орны 3 дугаарт Монгол улс орж байна.

2011 онд Монгол улсын Мянганы хөгжлийн зорилт, Үндэсний хөгжлийн цогц бодлого–Сүрьеэтэй тэмцэх үндэсний стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулахад гарсан ололт амжилтаа улам бататган цаашид анхаарвал зохих асуудлуудын хүрээнд “Сүрьеэгийн тусламж үйлчилгээний хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх” уриан дор Улаанбаатар хотноо Сүрьеэгийн үндэсний VI зөвлөгөөн болж өндөрлөлөө.

Хүснэгт 2.1.5. Сүрьеэгийн өвчлөл, нас баралтын түвшин (100 000 хүн амд), сонгосон онуудаар

Үзүүлэлт	1990	2000	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2015
Сүрьеэгийн өвчлөлийн түвшин										
Улсын дундаж	79	125	175	185	166	159	156	154	143	100.0 ^a
УБ хот	85	180	264	259	225	227	213	212	179	-
Аймгийн дундаж	63	99	123	132	123	115	113	115	113	-
Сүрьеэгийн нас баралтын түвшин										
Улсын дундаж	4.8	3.2	4.0	2.9	2.5	2.7	2.8	3.3	2.2	2.0 ^a
УБ хот	5.4	2.5	3.3	3.3	2.3	3.2	2.7	4.4	2.4	-
Аймгийн дундаж	3.9	2.0	4.3	2.5	2.6	2.4	2.9	2.5	1.9	-
ДОТС-ын хүрээнд эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь										
Улсын дундаж	-	100/80	100/79	100/82.1	100/83.8	100/85.0	100/84.2	100/84.5	100/83.0	100.0 ^a
УБ хот	-	100/84	100/74	100/78.4	100/80.6	100/83.2	100/80.2	100/81.7	100/79.8	-
Аймгийн дундаж	-	100/81	100/84	100/87.1	100/88.0	100/87.2	100/88.0	100/87.5	100/78.3	-

Эх үүсвэр: а.УИХ-ын тогтоол #13, Монгол Улсын МХЗ-уудыг батлах тухай, 2008

Сүрьеэгийн өвчлөлийн түвшин 1990 онд 100 000 хүн амд 79 байсан бол 2000 онд 1.5 дахин, 2004-2006 онуудад 2-2.3 дахин нэмэгдсэн байна. 2007 оноос эхлэн өвчлөл буурч эхэлсэн бөгөөд 100 000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин 2007 онд 166, 2008 онд 159, 2009 онд 156, 2010 онд 154, 2011 оны байдлаар 143 болон буурсан үзүүлэлттэй байна.

Сүрьеэ өвчний улмаас нас барсан хүмүүсийн тоо харьцангуй буурч байна. Сүрьеэ өвчний улмаас 1992-1995 онуудад жилд дунджаар 121 хүн нас барж байсан бол 1996-1999 онуудад 113, 2000-2003 онуудад 75, 2004-2009 онуудад 80 хүртэл буурч, 2011 оны байдлаар 60 болон буурчээ.

Сүрьеэгээр өвчлөгсдийн 79 хувь нь 15-49 насны хөдөлмөрийн насны хүмүүс байгаа бөгөөд хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн өвчлөл 52.8 хувь, эмэгтэйчүүд 47.2 хувь байна.

2011 оны байдлаар улсын хэмжээнд сүрьеэгийн 3985 тохиолдол шинээр бүртгэгдэж, нийт тохиолдлын 60 хувийг уушгины сүрьеэ, 40 хувийг уушгины бус эрхтний сүрьеэ эзэлж байна. Хүүхдийн сүрьеэгийн 419 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь сүрьеэгийн нийт шинэ тохиолдлын дотор 11 хувийг эзэлж байна.

Дэлхийн бусад улс орнуудын адил манай улс 1996 оноос шууд хяналттай богино хугацааны эмчилгээний стратеги (ДОТС)-ийг нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотойгоор сүрьеэгийн тархалт, нас баралтыг хяналтандаа авч чадсан байна. ДОТС-ын хүрээнд эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь 2011 онд 83 байна.

2011 оны байдлаар оношийн баталгаажилт 74.1 хувь, эдгэрэлтийн түвшин 83 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад оношийн баталгаажилт 0.7 хувиар, эдгэрэлтийн түвшин 1.5 хувиар тус тус буурсан байна.

БҮЛЭГ 3. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

3.1. Эхийн эрүүл мэнд


Монгол Улсын Засгийн газраас хүн амын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогыг тодорхойлсон бөгөөд төрөлтийг дэмжих бодлого арга хэмжээг авч хэрэгжүүлсний дүнд сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдэж байна.

2011 онд шинээр баригдах “Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв”-ийн барилгын 19.0 тэрбум төгрөг, Клиникийн нэгдүгээр амаржих газрын өргөтгөлийн 7.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн нь эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад бодитой хувь нэмэр болно.

Шинээр баригдаж буй эх, хүүхдийн эрүүл мэндийн төв, амаржих газруудад ажиллах хүний нөөцийг бэлтгэх, багаж тоног төхөөрөмжөөр хангах, санхүүжилтийг төлөвлөгөөтэй нэмэгдүүлэх гүйцэтгэлийг эрчимжүүлж, салбар хоорондын уялдааг сайжруулах нь чухал билээ.

“Амаржих газрын бүтэц, үйл ажиллагааны стандарт” MNS 2010/ 6188 үндэсний стандартыг батлан мөрдөж эхэлсэн нь эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэхэд чухал ахиц болоод байна.

Зураг 3.1.1. Эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд, /2001-2011 он/



2010-2011 онд хэрэгжүүлэхээр шинээр батлагдсан тушаал, журам

- ❖ Эх нярайд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, тэгш, чанартай үзүүлснээр эх нярайн өвчлөл эндэгдлийг тогтвортой бууруулна гэсэн алсын хараатай “Эх нярайн эрүүл мэнд (2011-2015) стратеги хэрэгжиж байна
- ❖ Амаржих газрын бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 6188/2010
- ❖ “Умайн хүзүүний өмөн” эмнэлзүйн удирдамж, 2011
- ❖ “Хөхний өмөн” эмнэлзүйн удирдамж, 2011
- ❖ “Эхийн эндэгдлийг бууруулах арга хэмжээний тухай” 2009 оны 149 тоот
- ❖ “Жирэмсэлт, төрлөгийн хүндрэлийг удирдах арга зүй” удирдамж 2011 оны 42 дугаар тушаал
- ❖ “Үр хөндөлтийг зохицуулах журмыг шинэчлэн батлах тухай” 2010 оны 105 дугаар тушаал
- ❖ “Төрөлхийн тэмбүү өвчнөөс сэргийлэх стратеги”-ийн хүрээнд жирэмсэн эмэгтэйн тэмбүү өвчнийг эрт оношлох, эмчлэх 350 дугаар журам

2011 онд эх, хүүхдийн эрүүл мэндийн талаар

- ❖ “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний V дугаар бага хурал зохион байгуулагдлаа. Монгол улс “НҮЭМ” Үндэсний 3 удаагийн хөтөлбөр, эхийн эндэгдлийг бууруулах 2 удаагийн стратегийг амжилттай хэрэгжүүлсний дүнд эх хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтүүд сайжирч, тодорхой амжилтанд хүрснийг энэхүү хурлаар тэмдэглэж, эх хүүхдийн эрүүл мэндийн асуудлаар хүрсэн үр дүн, амжилтаа бататган, өмнөх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн явцаас сургамж авч, цаашид тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор дараагийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх нь чухал юм. Тус хуралдаанд жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн эхийн хүндрэл, нярайн болон ургийн гаж хөгжлийг эрт оношлох, эмчлэх орчин үеийн багаж тоног төхөөрөмж дутагдалтай байгааг дурьдсан.
- ❖ “Эх нярайн эрүүл мэндийн стратеги”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулах зорилгоор хүүхдийн нас баралтын эмнэл зүй эмгэг судлалын хурлыг ярилцлага, хэлэлцүүлэг хэлбэрээр бүсчлэн зохион байгуулагдлаа.
- ❖ Олон улсын эх баригчдын өдрөөр “Эх баригч-эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулахад чухал үүрэгтэй” уриан дор тэмдэглэж, нийслэлийн амаржих газар, дүүргүүдийн эрүүл мэндийн нэгдэл, хувийн хэвшлийн эмнэлгүүдэд ажиллаж буй 180 эх баригч нарт сургалт зохион байгуулагдлаа.
- ❖ Хүүхдийг эхийн сүүгээр хооллох Азийн түншлэлийн VIII форум нь “Нялхсын хүнсний аюулгүй байдал ба уур амьсгалын өөрчлөлт” сэдвийн дор явагдсан байна.

3.2. Жирэмсэн үеийн буюу төрөхийн өмнөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ

2011 оны байдлаар нийт хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 85.5 хувь нь жирэмсний эрт үедээ буюу эхний 3 сартайдаа хяналтад хамрагджээ. Хот, хөдөөгөөр авч үзвэл хотод 82.4 хувь нь, хөдөө орон нутагт тухайн эмэгтэйчүүдийн 88.2 хувь нь жирэмсний эрт үеийн хяналтад хамрагдсан байна. Хожуу буюу 7 ба түүнээс дээш сартайд хамралтын хувь 1.1 байна.


Жирэмсний хяналтад орсон эмэгтэйчүүдийг шинжилгээнд хамруулах нь цус багадалт, жирэмсний хожуу хордлого, бөөрний эмгэг, ургийн болон бусад эмгэгийг эрт илрүүлж, холбогдох хүндрэлээс сэргийлэх боломж бүрддэг. Эрүүл мэндийн сайдын 2004 оны 197 дугаар тушаалын дагуу “Жирэмсэн эмэгтэйчүүдэд ХДХВ/ДОХ-ын үзлэг, шинжилгээ хийх журам”-ын дагуу жирэмсэн эмэгтэйгээс зөвшөөрөл авсны үндсэн дээр шинжилгээ хийхийг заасан. Мөн жирэмсэн эмэгтэйн тэмбүү өвчнийг эрт оношлох, эмчлэх эмчлэх тухай ЭМС-ын 2011 оны 350 дугаар тушаал гарснаар энэхүү журмыг мөрдөж эхэлж байна.

Шинээр хяналтад орсон нийт жирэмсэн эхчүүдийн 95.4 хувь нь цусны ерөнхий шинжилгээнд хамрагдснаас 6.1 хувь нь цус багадалттай байна. Баян-Өлгий болон Дорнод аймагт шинжилгээгээр цус багадалтай жирэмсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь улсын дүнгээс 2-3.5 дахин их байна.

Хяналтад хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн 96.9 хувь тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээ хийлгэсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.7 пунктээр

нэмэгдсэн байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээнд хамрагдсанаас 2.5 хувьд нь тэмбүү өвчин илэрсэн ба энэ үзүүлэлт Говьсүмбэр 5.2, Орхон 3.2, Улаанбаатар 3.9 хувьтай улсын дундаж үзүүлэлтээс өндөр байна. Нийт жирэмсэн эмэгтэйчүүдийн 80.3 хувь нь рентген шинжилгээнд хамрагдаж идэвхитэй сүрьеэгийн 60 тохиолдол илэрсний 73.3 хувь нь Улаанбаатар хотод байна.


Зураг 3.2.1. Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь, 2011 он



2011 онд эхчүүдийн амрах байр улсын хэмжээнд 339 ажиллаж байгаагаас 303 нь сумын төвд, 10 нь тосгоны эмнэлэгт, 22 нь аймгийн төвд, Улаанбаатар хотын эмнэлэгт 3, бусад газар 1 ажилласан байна. Эхчүүдийн амрах байрны 121 нь зориулалтын байранд байгаа ба 218 нь эмнэлэг дотор байрлаж байгаа ба нийт 83886 ор хоног ашиглаж дундаж ор хоног 6.0 байна. Энэ онд 14 амрах байр шинээр баригдаж, 41 байранд засвар үйлчилгээ, тохижилт хийгдсэн байна. Нийт амарвал зохих эхчүүдийн 77.9 нь амрах байранд амарсан байна.

2011 оны байдлаар нийт төрсөн эхчүүдийн 81.7 хувь нь жирэмсний хугацаандаа 6 ба түүнээс дээш удаа үзүүлж хяналтад байж төрсөн байна.


Зураг 3.2.2. Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, 2011 он



3.3. Төрөлт, төрөх үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ

2011 онд улсын хэмжээнд 70328 эх амаржсан нь 2010 онтой харьцуулахад төрөлт 4668 тохиолдлоор буюу 6.6 хувиар нэмэгдсэн байна. Төрөлт Булган, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ аймагт буурч бусад аймгууд болон Улаанбаатар хотод нэмэгджээ. Эдгээр аймгуудад төрөлтийн тоо буурсан боловч 2010 оны 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшингээр Говьсүмбэр аймагт буурч бусад аймагт нэмэгдсэн байна. 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 25.3 байгаа ба энэ үзүүлэлт Ховд 31.0, Баян-Өлгий 28.8, Дорнод 28.6, Орхон 28.3, Баянхонгор 27.5, Хөвсгөл 26.9, Увс 26.9, Улаанбаатар 26.8, Дархан 26.1, Говьсүмбэр 26.0 аймгуудад улсын дунджаас өндөр байна.

Зураг 3.3.1. 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин, аймгаар, 2011 он



Нийт төрөлтийн 44.9 хувь нь Улаанбаатар хотод, 30.6 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 11.1 хувь нь Бүсийн оношлогоо эмчилгээний төвд, 9.4 хувь нь сум, сум дунд, тосгоны эмнэлэгт, 2.6 хувь нь хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт, 1.0 хувь хувийн эмнэлэгт, 0.3 хувь нь гэртээ төрсөн байна. Төрсөн эхчүүдийн 40.2 хувь нь анхны төрөлт байгаа ба нийт төрөлтийн 3.6 хувийг их эмч, 89.9 хувийг эх барих, эмэгтэйчүүдийн их эмч, 6.5 хувийг эх баригч бага эмч удирдан явуулсан байна. 20-оос доош насны төрөлтийн эзлэх хувь 5.9 байгаа ба 35-иас дээш насны төрөлтийн эзлэх хувь 12.3 байна. ДЭМБ-аас нийт төрөлтийн 5-15 хувь нь мэс заслын аргаар төрсөн байж болно гэж зөвлөдөг боловч манай улсын хувьд харьцангуй өндөр буюу 21.6 хувь нь мэс заслын аргаар хүүхдээ төрүүлсэн байна. Мэс заслын аргаар төрлөгийн шийдсэн хувь баруун бүсэд аймгийн дүнгээс 2.6 пунктээр бага, бусад бүсэд 0.6-1.1 пунктээр их байна.


Хүснэгт 3.3.1 Мэс заслын аргаар төрүүлсэн хувь, бүсээр 2011 он

	Төрсөн эх	Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь
Баруун бүс	9622	13.3
Төвийн бүс	8957	16.5
Хангайн бүс	13254	17.0
Зүүн бүс	4764	16.5
Аймгийн дүн	36597	15.9
Улаанбаатар	33731	27.8
Улсын дүн	70328	21.6

Гэртээ төрсөн эхчүүдийн хувь хэмжээ буурч өнгөрсөн оны мөн үеэс 0.2 пунктээр буюу 89 тохиолдлоор буурчээ. Нийт гэрийн төрөлтийн 234 тохиолдлын 117 тохиолдол буюу 50.0 хувь нь эмнэлгийн тусламжгүй төрсөн нь өмнөх онтой харьцуулахад 5.1 пунктээр нэмэгдсэн байна.

Гэрийн төрөлтийн 61.1 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бөгөөд өмнөх оноос 5.3 пунктээр нэмэгдсэн байна. Энэ нь Улаанбаатар хотод шилжин ирэгсэд нэмэгдэж хаягийн бүртгэлгүй болон жирэмсний хяналтад хожуу орж байгаа шалтгаантай холбоотой юм.

Зураг 3.3.2. Мэс заслын аргаар төрсөн эхийн хувь, аймгаар, 2011 он



Хүснэгт 3.3.2 Төрөлтийн тоо, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2011 он

Аймаг, хот	Нийт төрөлт	Үүнээс гэртээ	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт	Сум, сум дундын эмнэлэгт	Тосгоны эрүүл мэндийн төв	Ортой, их эмчийн салбар	УБ хотын амаржих газар болон ЭХЭМҮТ-д	Хувийн эмнэлэгт
Архангай	2005	3	1346	0	655	0	1	0	0
Баян-Өлгий	2569	0	1915	0	654	0	0	0	0
Баянхонгор	2098	6	1725	0	357	10	0	0	0
Булган	962	5	665	0	277	15	0	0	0
Говь-Алтай	1310	2	1113	0	190	1	4	0	0
Говьсүмбэр	352	1	351	0	0	0	0	0	0
Дархан-Уул	2496	12	2405	0	79	0	0	0	0
Дорноговь	1348	1	1117	194	36	0	0	0	0
Дорнод	1993	3	1883	0	107	0	0	0	0
Дундговь	766	0	623	0	143	0	0	0	0
Завхан	1383	5	792	310	276	0	0	0	0
Орхон	2570	13	2538	0	19	0	0	0	0
Өвөрхангай	2511	12	1603	246	603	0	2	0	45
Өмнөговь	1213	1	1012	0	200	0	0	0	0
Сүхбаатар	1288	7	1147	0	134	0	0	0	0
Сэлэнгэ	1859	2	930	631	250	46	0	0	0
Төв	923	1	576	0	346	0	0	0	0
Увс	1964	13	1363	0	588	0	0	0	0
Ховд	2396	0	1770	208	418	0	0	0	0
Хөвсгөл	3108	2	2095	0	1011	0	0	0	0
Хэнтий	1483	2	1038	233	205	0	5	0	0
Аймгийн дүн	36597	91	28007	1822	6548	72	12	0	45
Улаанбаатар	33731	143	1368	0	6	0	0	31571	643
Улсын дүн	70328	234	29375	1822	6554	72	12	31571	688

3.4. Төрсний дараах тусламж, үйлчилгээ

2011 оны эрүүл мэндийн статистикийн бүртгэлээр хяналтад байж төрсөн эхчүүдээс төрсний дараа 42 хоногтойдоо эмчийн идэвхитэй хяналтад хамрагдсан хувь 87.8 байгаа нь өнгөрсөн оны байдалтай адил түвшинд байна. Энэ үзүүлэлт төрсний дараах хүндрэл болон эхийн эндэгдэл буурахад чухал ач холбогдолтой билээ.

2011 оны статистик үзүүлэлтээр нийт төрсөн эхчүүдийн 30.0 хувь нь жирэмсэн байх үедээ ямар нэгэн хавсарсан өвчнөөр өвдсөн байна. Үүнээс:

- Шээс бэлгийн тогтолцооны өвчин- 29.2 хувь
- Зүрх-судасны тогтолцооны өвчин- 10.2 хувь
- Хоол шингээх эрхтний өвчин- 7.4 хувь эзэлж эхний 3 шалтгаанд тэргүүлж байна.

Мөн 2011 оны байдлаар жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлийн нийт 47057 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 666.7 байна. Нийт тохиолдлын:

- жирэмсэн үеийн хүндрэл- 35.4 хувь,
- төрөх үеийн хүндрэл- 52.3 хувь,
- төрсний дараах үеийн хүндрэл- 1.4 хувь,
- жирэмсэн төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл- 10.8 хувийг тус тус эзэлж байна.

2010 оны үеэс жирэмсэн эмэгтэйчүүд болон төрсөн эхчүүдийн дундах өвчлөл 1365 тохиолдлоор буурсан байна. Жирэмсэн, төрөхөөс үл хамаарах өвчний хүндрэл өмнөх оноос буурсан нь нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн гэр бүл төлөвлөлтийн мэдлэг нэмэгдсэн болон жирэмсний хяналтад эрт хамрагдаж байгаатай холбоотой юм.

2011 онд төрөлхийн тэмбүүгийн нийт 15 тохиолдол бүртгэгдсэнээс Баянхонгор 2, Дорнод 1, Орхон 2, Өмнөговь, Төв, Увс 1, Хөвсгөл 2, Улаанбаатар хотод 5 тохиолдол гарч өнгөрсөн оноос 4 тохиолдлоор нэмэгдсэн байна. Жирэмсэн эмэгтэйчүүд БЗДХалдвартай байх болон төрөлхийн тэмбүүтэй хүүхэд төрөх тохиолдол нэмэгдэж байгаа нь жирэмсэн эмэгтэйн тэмбүү өвчнийг эрт оношлох, эмчлэх журмын дагуу тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах хэрэгтэйг харуулж байна.

ДЭМБ-ын дэмжлэгтэй “Жирэмсний хяналтад тэмбүү өвчнийг илрүүлэх нэг цэгийн үйлчилгээ”-г судлах судалгаагаар нэг цэгийн үйлчилгээ нь жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах тэмбүү өвчний илрүүлэлт, эмчилгээ болон хавьтагчийн эмчилгээг сайжруулж улмаар төрөлхийн тэмбүүгээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөөтэй болохыг судлан тогтоосон.

Өнөөгийн байдлаар энэхүү нэг цэгийн үйлчилгээ нь Улаанбаатар хот болон зарим аймгуудад хэрэгжиж эхлээд байгаа бөгөөд “Төрөлхийн тэмбүү өвчнөөс сэргийлэх үндэсний стратеги 2011-2015”-ийн гол үйл ажиллагааны хэсэг болсон. Жирэмсэн үеийн хүндрэлүүдээс манас таталтын урьтал болон манас таталт 60.1 хувь, төрөх үеийн хүндрэлээс төрөх хүчний анхдагч болон хоёрдогч сулралт 30.8 хувь, төрсний дараах үеийн хүндрэлээс хожуу үеийн цус алдалт 44.8 хувьтай тэргүүлж байна.

3.5. Эхийн эндэгдэл


Дэлхийн мянганы хөгжлийн тав дах зорилтод эхийн эндэгдлийг 2015 онд 1990 оны түвшингээс 75%-иар бууруулахаар заасан. Ази-Номхон далайн баруун эргийн бүсийн орнуудад жилд 40-50 сая жирэмслэлт бүртгэгдэж, жирэмслэлт, төрөх, төрсний дараах үедээ 30500-50000 эх эндэж, 300000 нярай амьдралын эхний хоногтоо эндэж байна.

Өнөөдөр манай улсад эхийн эндэгдэл 1990 оны түвшингээс бараг дөрөв дахин буурч, эхийн эндэгдэл өндөр орноос эхийн эндэгдэл дунд зэрэгтэй орны түвшинд хүрээд байна.

2011 оны байдлаар эхийн эндэгдлийн 34 тохиолдол бүртгэгдэж 100 000 амьд төрөлтөд 48.2 байна. 2010 оны үеэс 4 эндэгдлээр буюу 13.3 хувиар нэмэгдсэн бөгөөд Баянхонгор, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Төв, Увс, Хэнтий зэрэг аймгуудад эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна. Эндсэн эхчүүдийн 82.4 хувь нь эмнэлэгт, 14.7 хувь нь гэртээ, 2.9 хувь нь тээврийн хэрэгслэлд эндсэн байна.

Эндсэн эхчүүдийг боловсролоор нь авч үзвэл 23.5 хувь нь бага боловсролтой, 61.8 хувь нь дунд, 5.9 хувь нь мэргэжлийн болон техникийн, 8.8 хувь нь дээд боловсролтой байжээ. Түүнчлэн 8.8 хувь нь ажил эрхэлдэг, 35.3 хувь малчин, 5.9 хувь нь оюутан, 3.0 хувь нь бусад салбарт, 47.0 хувь ажил эрхэлдэггүй байсан байна.


Хүснэгт 3.5.1 Эхийн эндэгдэл, эмнэлгийн байгууллагын төрлөөр, 2011 он



Эхийн эндэгдлийн эмнэлгийн нас баралтыг эмнэлгийн байгууллагын төрлөөр авч үзвэл 17.8 хувь нь сум, сум дундын эмнэлэгт, 28.6 хувь нь аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт, 53.6 хувь нь Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төрөлжсөн эмнэлэгт эндсэн байна.

2011 онд эндсэн эхийн 17.6 хувь нь жирэмсний хяналтанд огт ороогүй, 53.6 хувь нь жирэмсний хожуу хугацаанд буюу 12 долоо хоногоос хожуу хугацаанд жирэмсний хяналтанд оржээ.

Эндсэн эхчүүдийн 41.2 хувь жирэмсний үеийн хүндрэл, 15.0 хувь нь төрөх үеийн хүндрэл, 11.8 хувь нь төрсний дараах хүндрэл, 32.4 хувь нь жирэмсэн болон төрөхөөс бусад өвчний улмаас эндсэн байна. Энэ үзүүлэлтээс харахад өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төрөх үеийн хүндрэл 5.3 пункт, жирэмсэн төрөхөөс үл хамаарах өвчний шалтгаан 24.3 пунктээр тус тус буурсан байна. Харин жирэмсэн үеийн хүндрэлийн шалтгаант эндэгдлийн хувь 3 дахин ихэссэн нь жирэмсний хяналтын чанарыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. Эндсэн эхчүүдийг насны ангиллаар авч үзвэл 73.0 хувийг 20-34 нас, 21.0 хувийг 35-аас дээш, 6 хувь нь 15-19 насанд бүртгэгдсэн байна.

Зураг 3.5.2. Эхийн эндэгдэл бүсээр, 100 000 амьд төрөлтөд, 2011 он

Эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд бүс нутгаар авч үзвэл баруун болон хангайн бүсэд улсын дунджаас 14.4-19.5 –ээр их харин зүүн болон төвийн бүсэд 6.0-25.9 –ээр бага байна. Баруун бүсэд эхийн эндэгдэл 100 000 амьд төрөлтөд улсын дунджаас их байгаа боловч сүүлийн 3 жилээс хамгийн бага түвшинд хүрч буурсан байна. Төвийн бүсэд эхийн эндэгдлийн түвшин 100 000 амьд төрөлтөд 2008-2011 онд тогтвортой буурсан байна.

3.6. Хүүхдийн эрүүл мэнд ба хөхөөр хооллолт

Шинээр төрсөн хүүхдийг нярай үед нь буюу төрсний дараах нэг сар хүртэлх хугацаанд нь хамрагдвал зохих эрүүл мэнд нийгмийн үйлчилгээнд хамруулснаар амьдрах боломжийг нэмэгдүүлж, хэвийн өсөлт хөгжилтэй, эрүүл саруул өсөх үндэс болдог. Албан ёсны статистик үзүүлэлтээр төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 93.0 байна. Энэ үзүүлэлт Хэнтий, Дархан-Уул, Сүхбаатар, Архангай аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3.6.1 Төрсөн хүүхдийн мэдээ, бүсээр, 2011 он

Бүсээр	Төрсөн хүүхэд				Нийт төрөлтөд	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа /100-д/	Бага жинтэй хүүхдийн эзлэх хувь	Амьгүй төрөлтийн түвшин /1000 төрөлтөд /
Баруун бүс	9593	4974	4619	107.7	3.5	12.7
Төвийн бүс	8975	4344	4631	93.8	3.2	5.5
Хангайн бүс	13293	6782	6511	104.2	4.5	7.0
Зүүн бүс	4791	2454	2337	105.0	4.4	5.6
Аймгийн дүн	36652	18554	18098	102.5	3.9	8.0
Улаанбаатар	33924	17447	16477	105.9	4.5	6.0
Улсын дүн	70576	36001	34575	104.1	4.2	7.0

Улсын хэмжээнд 70576 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 4687 хүүхдээр буюу 6.6 хувиар нэмэгдсэн байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 4.2 хувь нь 2500 граммаас доош жинтэй төржээ. Амьд төрсөн хүүхдээс 1480 нь хоёр ихэр, 12 нь гурван ихэр байна. Амьгүй төрөлт 1000 төрөлтөд 7.0 байгаа ба нийт 500 тохиолдлоос баруун бүсэд 12.7 промилль байгаа нь улсын дүнгээс өндөр байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 төрөлтөд Баян-Өлгий аймагт 20.4 байгаа нь баруун бүс болон улсын дунджаас 5-7 промилль-ээр их байна. Амьгүй төрөлтөд эрэгтэй хүүхдийн эзлэх хувь 54.8 байгаа ба ихэнхи бүс нутгуудад өндөр байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа -104.1 байна. 2011 онд 1 хүртэлх насны хүүхдийн идэвхитэй хяналтын хувь 99.3, 5 хүртэлх насны хүүхдийн идэвхитэй хяналтын хувь 94.6 байна.

3.7. Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

МХЗ-уудыг батлах тухай УИХ-ын 13 дугаар тогтоолоор мянганы хөгжлийн зорилтын хүрээнд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийг 2015 онд 15.0, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 21.0 болгохоор баталсан.

2011 оны байдлаар улсын хэмжээнд нялхсын эндэгдэл 1152 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 16.3 байна. Өнгөрсөн оны үетэй харьцуулахад 123 тохиолдол буюу 10,7 хувиар буурч, 1000 амьд төрөлт тутамд 3.1 эндэгдлээр буурсан байна. Нялхсын эндэгдлийн 51.6 хувь нь нярайн эрт үед, 11.0 хувь нь нярайн хожуу үед, 37.3 хувь нь 29-365 хүртэлх хоногтойдоо эндсэн байна. Нярайн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 10.2 байна.

Харин 5 хүртлэх насандаа 1410 хүүхэд эндсэн бөгөөд амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох түвшин 20.0 байна. Нийт эндэгдлийн 56.3 хувь нь эрэгтэй, 43.7 хувь нь эмэгтэй хүүхэд байна. 1000 амьд төрөлтөд ногдох эндэгдлийн үзүүлэлтээр Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Орхон, Сэлэнгэ зэрэг аймгуудад болон Улаанбаатар хотод улс болон аймгийн дунджаас бага байна.

5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 87.8 хувь нь өвчнөөр 12.1 хувь нь гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад эмгэг, 0.07 хувь тодорхой бус шалтгааны улмаас эндсэн бөгөөд 76.8 хувь нь эмнэлэгт, 19.6 хувь нь гэртээ, 3.6 хувь нь бусад газар байна. Энэ нь 5 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналт болон эцэг эхийн хайр халамж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зэрэгт анхаарах хэрэгтэйг харуулж байна.

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд перинаталь үед үүссэн зарим эмгэг 49.8 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 20.7 хувь, төрөлхийн гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг 12.3 хувь байгаа нь эхний тэргүүлэх 3 шалтгаан болж байна. Нялхсын эндэгдлийн шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчин өмнөх оны мөн үеэс 0.9 пункт-ээр буурч, төрөлхийн гажгийн тохиолдлын шалтгаан 0.3 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3.7.1. Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтын шалтгаан, хувиар (хот, хөдөө) 2011 он

	1 хүртэлх насны		5 хүртэлх насны	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын тогтолцооны өвчин	16.9	23.1	17.3	24.9
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	3.3	4.8	3.5	5.3
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	50.9	49.1	41.6	40.1
Төрөлхийн гажиг, гаж хөгжил ба хромосомын эмгэг	19.3	7.8	17.8	8.0
Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан	3.3	8.0	10.7	13.1

	Тэргүүлэх шалтгаан
	Хоёрдугаар шалтгаан
	Гуравдугаар шалтгаан

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд хот болон хөдөөд перинаталь үед үүссэн зарим эмгэг өвчлөлийн хамааралтай нас баралт тэргүүлэх шалтгаан болж байна. Перинаталь үед үүссэн зарим эмгэг дотор төрөх үед ураг бүтэх болон нярайн амьсгалын дутагдал дийлэнхи хувь буюу 47 хувийг эзэлсэн байна. Төрөлхийн гажигийн дотор зүрхний төрөлхийн гажиг нь хамгийн их буюу 44 хувь, олон эрхтэн тогтолцоог хамарсан төрөлхийн гажиг 8 хувь, улаан хоолойн төрөлхийн гажиг 8 хувь, цөсний хүүдийн гажиг 4 хувь үлдсэн 36 хувийг бусад эрхтэн тогтолцооны гажиг тус тус эзэлж байна.

Хүснэгт 3.7.2 Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаан, (хот, хөдөө), 2011 он

	1 хүртэлх насны		5 хүртэлх насны	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Амьсгалын тогтолцооны өвчин	56.3	67.8	50.8	65.5
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	12.9	12.0	11.1	12.9
Перинаталь үед үүссэн зарим эмгэг	9.9	1.8	3.5	0.6
Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан	3.0	1.0	9.7	2.1
Халдварт ба шимэгчт зарим өвчин	1.5	0.4	5.3	3.4
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	4.1	3.0	8.0	3.9
Чих ба хөхлөг сэртэнгийн өвчин	2.1	5.7	2.0	4.4

	Тэргүүлэх шалтгаан
	Хоёрдугаар шалтгаан
	Гуравдугаар шалтгаан

Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлд хот, хөдөөд амьсгалын тогтолцооны өвчин адилхан тэргүүлэх шалтгаан болж байна. Ялангуяа бага насны хүүхдийн дунд амьсгалын тогтолцооны өвчлөлөөс уушгины хатгалгаа 34.4 хувь томуу, томуу төст өвчлөл 15.3 хувь, цочмог бронхит 17.2 хувь тус тус зонхилох хувийг эзэлж байна.

Хүснэгт 3.7.3. Хүүхэд, өсвөр үеийнхний өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, насны бүлгээр, /10 000 хүн амд/, 2011 он

	1-4 нас	5-9 нас	10-14 нас	15-19 нас
Амьсгалын тогтолцооны өвчин	3890.0	962.8	804.6	598.4
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	810.4	666.3	647.6	646.8
Халдварт ба шимэгчт зарим өвчин	395.2	296.5	172.6	160.1
Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан	452.4	292.2	346.9	431.9
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	111.4	113.6	211.5	445.8
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	439.6	266.5	299.9	413.7

	Тэргүүлэх шалтгаан
	Хоёрдугаар шалтгаан
	Гуравдугаар шалтгаан

Өсвөр насны хүүхдийн өвчлөлд амьсгал, хоол боловсруулах тогтолцооны болон арьс арьсан доорх эслэгийн өвчин дийлэнх тохиолдлыг эзэлж байна. Жилээс жилд гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг өсвөр үеийнхний дунд нэмэгдэж, 2011 онд 15-19 насны хүүхдийн дунд 10 000 хүүхэд тутамд 7.5 өвчлөлөөр нэмэгдсэн байна. Харин 1-4 нас хүртэлх насны хүүхдийн осол гэмтлийн өвчлөл 10 000 хүн амд 63.4 промилль-оор нэмэгдсэн байна. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл 10 000 хүүхдэд халдварт бус суулгалт 1-4 насанд 467.9, 5-9 насанд 74.3, мөн шүд ба дайвар бүтцийн эмгэг 10-14 насанд 199.0, 15-19 насанд 165.5 өвчлөл бүртгэгдэж тэргүүлэх шалтгаан болж байна.

3.8. Үр хөндөлт

Эрүүл мэндийн 2011 оны статистик мэдээгээр үр хөндөлтийн 17504 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 248.0, нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд 20.5 үр хөндөлт ногдож байна. Өнгөрсөн оны мөн үеэс 5012 тохиолдлоор буюу 1000 амьд төрөлт тутам ногдох түвшин 58.0 үр хөндөлтөөр нэмэгдсэн бөгөөд Говьсүмбэр, Дорноговь, Орхон, Өвөрхангай аймгууд болон Улаанбаатар хотод улсын дунджаас 3.1-28.8 промилль-оор өндөр байна. Мөн хувийн эмнэлгээр хийгдсэн үр хөндөлт өмнөх оноос 1.9 дахин нэмэгдсэн байна. Хожуу үеийн үр хөндөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд 6.9 промилль байгаа ба өнгөрсөн жилтэй харьцуулахад 1.6 промилль-оор нэмэгджээ. Үр хөндөлт хийлгэж буй эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 7.2 хувийг 20-иос доош насны, 73.7 хувийг 20-34 насны, 19.1 хувийг 35-аас дээш насны эмэгтэйчүүд тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны үетэй харьцуулахад 20-оос доош насны үр хөндөлтийн хувь 1.2 пунктээр нэмэгдсэн байна.

Үр хөндүүлсэн эмэгтэйчүүдийн 16.3 хувь нь төрөөгүй буюу анхны удаа үр хөндүүлсэн нь өмнөх оны мөн үетэй адил байна.

Үр хөндөлтийг байршлаар авч үзэхэд: сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт 0.3, хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт 0.8, бусад эмнэлэгт 0.4, хувийн эмнэлэгт 44.3, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт 11.9, бүсийн оношлогоо эмчилгээний төвд 8.4 хувь, амаржих газруудад 21.9 болон ЭХЭМҮТ-д 12.0 хувийг тус тус эзэлж байна.

3.9. Жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн аргын хэрэглээ /ЖСА/

2010 оны “Хүүхэд хөгжил 2010” судалгаагаар 15-49 насны гэрлэсэн болон хамтран амьдрагчтай эмэгтэйчүүд бараг бүгд ЖСАХ-ний талаар мэддэг боловч ердөө талаас дөнгөж илүү хувь нь (55 хувь) одоогоор буюу судалгааны үед жирэмслэхээс сэргийлэх ямар нэг арга, хэрэгсэл хэрэглэж байгаа нь 2011 оны байдлаар эрүүл мэндийн статистик үзүүлэлттэй (53.7) ойролцоо байна.

Нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйн 536.7 нь ямар нэг жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэглэдэг байна. Харин тэдний голчлон хэрэглэж байгаа нь бэлгэвч 32.7 хувь, ерөндөг 27.7 хувь, бэлдмэл /эм/ 23.4 хувь байна. Түүнчлэн судалгаагаар ЖСАХ-ийн хэрэгцээтэй нийт эмэгтэйчүүдийн 71 хувийнх нь хэрэгцээ хангагдсан байна гэсэн дүн гарчээ.

3.10. Үргүйдэл

Манай улсад үргүйдлийн тархалтыг тогтоосон судалгаа хийгдээгүй ч 2004 онд гэр бүлийн үргүйдлийн шалтгааныг тодруулах анхны судалгааг ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр ЭХЭМҮТ-ийн судлаачид хийсэн, уг судалгаагаар үргүйдлийн 45.8% эмэгтэйгээс, 25.6% эрэгтэйчүүдээс шалтгаалсан, 9.8% нь үргүйдлийн шалтгаан тодорхойгүй, 18.8% нь гэр бүлийн хосоос шалтгаалсан байна гэсэн дүгнэлт гарчээ. Өнөөдөр үргүйдэл нь тусламж үйлчилгээ шаардаж буй тулгамдсан асуудал болсон байна. Эмч мэргэжилтэн нарын үзэж байгаагаар БЗДХ-ын тархалт, үр хөндөлтийн түвшин буурахгүй байгаагаас үргүйдэлтэй үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж ялангуяа үргүйдэлтэй эмэгтэйчүүдийн дунд 2-гч үргүйдэл зонхилон тохиолдож байна.

БҮЛЭГ 4. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол улсын эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн эрүүл мэндийн, эмнэлгийн тусламж, үйлчилгээний, эм хангамжийн, анагаах ухааны боловсрол, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа хариуцсан төрийн, хувийн хэвшлийн, холимог өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэнэ.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг Өрхийн эрүүл мэндийн төв, Сум, тосгоны эрүүл мэндийн төв, Сум дундын эмнэлэг, Клиник, Амаржих газар, Нийгмийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Сувилал, Түргэн тусламжийн төв, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд үзүүлж байна.

Эрүүл мэндийн байгууллагууд тусламж үйлчилгээний шатлалаар, 2011 он

Эрүүл мэндийн байгууллагууд	Тоо
Өрхийн эрүүл мэндийн төв	219
Сум/ тосгоны эрүүл мэндийн төв	274/19
Сум дундын эмнэлэг	37
Дүүргийн нэгдсэн эмнэлэг	12
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	6
Аймгийн нэгдсэн эмнэлэг	17
Бүсийн оношлогоо эмчилгээний төв	4
Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд	16
Амаржих газрууд	3
Бусад эмнэлгүүд /Хилийн цэрэг, төмөр зам, хорихын эмнэлгүүд/	47
Ортой хувийн эмнэлэг	171
Үүдэн хувийн эмнэлэг	1013
Аршаан сувилал, сувилал	67
Эм ханган нийлүүлэх байгууллага	158
Эмийн үйлдвэр	42
Хувийн эмийн сан	703
Бусад	119
Бүгд	2927

4.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ

Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага юм.

АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Эрүүл мэндийн салбарын хөгжил-2” хөтөлбөрийн хүрээнд өрхийн эмнэлгүүдийг Улаанбаатар хот болон бүх аймгийн төвүүдэд үе шаттайгаар байгуулж, 2002 он гэхэд өрхийн эмнэлгийн тогтолцоонд шилжсэн билээ.

2011 оны байдлаар 219 өрхийн эрүүл мэндийн төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотын 1 265.7 мянган хүн амд 124 өрхийн эрүүл мэндийн төв, 21 аймгийн төвийн 590.4 мянган хүн амд 95 өрхийн эрүүл мэндийн төв эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.


Хүснэгт 4.1.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2011 он

Үзүүлэлт	Өрхийн эмнэлэг		Нийт дүн
	УБ хот	Аймаг	
Эмнэлгийн тоо	124	95	219
Их эмчийн тоо	497	288	785
Сувилагчийн тоо	474	282	756
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	4074640	1859950	5934590
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	42.0	31.8	38.8
Нэг иргэний жилд үзүүлсэн удаа	3.3	3.2	3.2
Нэг өрхийн эмчид ногдох үзлэгийн тоо	8198.4	6458.2	7559.9
Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	82.53	88.9	85.4

219 өрхийн эрүүл мэндийн төвд их эмч-785, сувилагч-756 болон нийт 2235 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна.

2011 онд өрхийн эрүүл мэндийн түвшинд жилд дунджаар 5.9 сая үзлэг хийгдэж, нэг иргэн жилд дунджаар 3.2 удаа өрхийн эмнэлэгт хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байна. Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь УБ хотын өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд 42.0 хувьтай, харин аймгийн өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд 31.8 хувьтай байна.

Зураг 4.1.1 Өрхийн эрүүл мэндийн төвд хийгдсэн амбулаторийн үзлэгийн тоо, 2011 он



УБ хотын өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд 2005 онд 3.0 сая үзлэг хийгдэж байсан бол 2007 онд 3.9 сая, 2011 онд 4.1 болж нэмэгдсэн байна. Жилд нэг өрхийн эмчид ногдох үзлэгийн тоо УБ хотод 8198.4 байгаа нь аймгийн түвшинд ажиллаж байгаа өрхийн нэг эмчид ногдох үзлэгээс 1740 үзлэгээр их байна. УБ хотын түвшинд өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ачаалал нэмэгдсэн нь сүүлийн жилүүдэд УБ хотын хүн амын тоо, төрөлтийн тоо, хөдөөнөөс УБ хотод шилжин ирж суурьшигчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж болно.


4.2. Сумын эрүүл мэндийн төвийн болон сум дундын эмнэлгийн тусламж, үйлчилгээ

Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийнхээ хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар үзүүлэх бөгөөд сумын эрүүл мэндийн төв нь тухайн сумын хүн амын тоо, байршлаас хамааран багийн эмчийн салбартай байж болно гэж заажээ. Сум дундын эмнэлэг нь хүн амын суурьшил, нягтралаас хамааран харьяалалын болон зэргэлдээ сумын хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ. 2001 онд батлагдсан “Сумын эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны улсын стандарт”-аар сумын эмнэлгүүд нь үйлчлэх хүрээний хүн амын тооноос хамааран 3 зэрэглэлд хуваагддаг. I зэрэглэлийн сумын эмнэлгийн үйлчлэх хүрээний хүн ам нь 4500 ба түүнээс дээш, ажиллах эмчийн доод хязгаарыг - 7, II зэрэглэлийн сумын эмнэлгийн хувьд 3001-4500 хүртэл хүн ам, ажиллах эмчийн доод хязгаарыг - 3, III зэрэглэлийн сумын эмнэлгийн хувьд 3000 хүртэл хүн ам, 1 эмч байхаар стандартад заасан байдаг.

Хүснэгт 4.2.1 Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүдийн их эмчийн хангамжийг стандартын доод хязгаартай харьцуулсан байдал, 2011 он

Зэрэглэл	Эмнэлгийн тоо	Эмчийн тоо (дундаж)	Стандартын доод хэмжээ	Стандартын түвшинд		Стандартаас доогуур	
				Тоо	Хувь	Тоо	Хувь
I зэрэглэл	31	4.4	7	2	6.5	29	93.5
II зэрэглэл	71	2.1	3	24	33.8	47	66.2
III зэрэглэл	172	1.8	1	172	100.0	0	0.0
Сум дундын эмнэлэг	37	4.6	8	2	5.4	35	94.6

Зураг 4.2.1 Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ногдох эмчийн дундаж тоо, 2010-2011 он



Дээрх хүснэгтээс харахад I зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн 6.5 хувь нь, II зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн 33.8 хувь, III зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төв 100.0 хувь стандартад заасан эмчээр хангагдсан байна.


III зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийн хувьд стандартаар доод тал 1 их эмч ажиллах ёстой бөгөөд 172 сумын эрүүл мэндийн төвөөс 59 (34.3 хувь) нь 1 их эмчтэй, 104 (60.5 хувь) сумын эрүүл мэндийн төв 2 их эмчтэй, 9 (5.2 хувь) нь 3 ба түүнээс олон их эмчтэй ажиллаж байна.

Хүснэгт 4.2.2 Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2009 он			2011 он		
	Сумын эрүүл мэндийн төв	Сум дундын эмнэлэг	Нийт дүн	Сумын эрүүл мэндийн төв	Сум дундын эмнэлэг	Нийт дүн
Эмнэлгийн орны тоо	3038	624	3662	2928	675	3603
Их эмчийн тоо	562	149	711	576	171	747
Сувилагчийн тоо	1373	246	2992	1341	243	1584
Дундаж ор хоног	7.8	6.4	7.1	8.0	7.8	7.9
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	114836	25110	139946	109720	22905	132625
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	2246335	362549	2608884	2009293	427516	2436809
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	39.8	40.8	39.9	39.5	37.5	39.2
Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	87.4	89.4	87.6	89.5	92.6	90.0
Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөд)	136.5	175.7	143.6	58.0	145.3	76.4
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)	42.2	29.9	39.9	36.2	28.3	34.5

2011 оны байдлаар эмнэлгийн нийт орны 19.0 хувь нь сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт ногдож байгаа бөгөөд 2009 онтой харьцуулбал 59 ороор буюу 1.6 хувиар буурсан байна. Сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт жилд 132.6 мянган хүн хэвтэн эмчлүүлсэн байна. 2011 хэвтэн эмчлүүлэгчдийн тоог 2009 онтой харьцуулахад сум дундын эмнэлэгт 8.8 хувиар, сумын эмнэлэгт 4.5 хувиар буурсан байна. Энэ нь эмнэлэгт хэвтэлтийн түвшинг багасгаж нийгмийн эрүүл мэндийг дэмжиж, өвчнөөс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлж байгаатай холбоотой юм.

Зураг 4.2.2 Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, орны эзлэх хувь, 2009-2011 он



Дундаж ор хоног 2009 онд 7.1 хоног байсан бол 2011 онд 7.9 болж нэмэгдсэн байна. Сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт нэг иргэний үзүүлсэн дундаж тоо 2009 онд 3.0 байсан бол 2011 онд 2.6 болон буурсан байна.

2011 онд сумын болон сум дундын эмнэлгийн түвшинд жирэмсний эрт үеийн хяналт 90.0 хувь болж 2009 оноос 2.4 хувиар нэмэгдсэн байна.

2011 онд нийт эндсэн эхийн 14.7 хувь (5 тохиолдол) нь сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлэгт эндсэн байна. 2009 онтой харьцуулахад 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин сум дундын эмнэлгийн түвшинд 30.4-оор, сумын эрүүл мэндийн төвийн түвшинд 78.5-оор буурсан байна.

2011 онд 1000 амьд төрсөн хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийн түвшин сумын эрүүл мэндийн түвшинд 36.2, сум дундын эмнэлгийн түвшинд 28.3 байна. Сумын эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлгийн нялхсын эндэгдлийн түвшин 2010 онтой харьцуулахад 1000 амьд төрөлт тутамд 7.2-оор буурсан байна.

4.3. Нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээ

Нэгдсэн эмнэлэг нь хүн амд 7-гоос доошгүй мэргэжлээр /дотор, хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, ерөнхий мэс засал, шүд, мэдрэл, халдварт/-ээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх бөгөөд хүн амын байршил, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг үндэслэн салбар амбулаторитой байж болно гэж Эрүүл мэндийн шинэчилсэн хуулинд заажээ.

Нийгмийн эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн түвшинд зохион байгуулна.

2011 оны байдлаар 17 аймгийн нэгдсэн эмнэлэгт 903 их эмч, 1515 сувилагч, 2108 эмнэлгийн дунд мэргэжилтэн, нийтдээ 4471 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 8 дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвд 711 их эмч, 766 сувилагч, 1027 эмнэлгийн дунд мэргэжилтэн, нийтдээ 2637 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллаж байна.

2001 онд аймгийн нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны улсын стандарт MNS 5095:2001 батлагдсан бөгөөд тус стандартыг дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд мөн адил мөрдөж байна.


Уг стандартад аймгийн нэгдсэн эмнэлэгт ажиллах эмчийн тоог аймгийн нийт хүн амын тоог харгалзан ялгавартай тогтоосон. 2011 оны байдлаар аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн 11.8 хувь буюу 2 эмнэлэг стандартын шаардлагыг хараахан хангаагүй байна.

Хүснэгт 4.3.1. Аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн их эмчийн хүртээмжийг стандартын доод хязгаартай харьцуулсан байдал, 2011 он

Аймгийн нийт хүн амын тоо	Эмчийн тоо (дундаж)	Стандартын доод хэмжээ	Стандартын түвшинд		Стандартаас доогуур	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
65500 хүртэл	45.3	37.5	8	88.9	1	11.1
65501-90500 хүртэл	58.6	50	5	100	0	0.0
90501-ээс дээш	67.0	58.5	2	66.7	1	33.3
Дундаж	-	-	15	88.2	2	11.8

Дээрх хүснэгтээс харахад 65500 хүн амтай аймгийн нэгдсэн эмнэлэгт ажиллаж байгаа эмчийн дундаж тоо стандартад заасан хэмжээнээс 7.8-аар, 65501-90501 хүртэл хүн амтай аймгийн нэгдсэн эмнэлэг 8.6-аар, 95501-ээс дээш хүн амтай аймгийн нэгдсэн эмнэлэгт ажиллаж байгаа эмчийн дундаж тоо стандартад заасан хэмжээнээс 8,5-аар их байгаа нь аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн орон тооны доод хязгаарыг шинэчлэн тогтоох шаардлагатай байгааг харуулж байна.


Зураг 4.3.1. Аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн их эмчийн хүртээмжийг стандартын доод хязгаартай харьцуулсан байдал, 2011



Аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд эмнэлгийн нийт орны 16.9 хувь нь ногдож байгаа бөгөөд 2011 онд аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн ор 3213 болж, 2009 онтой харьцуулахад 4 ор буюу 0.5 хувиар нэмэгдсэн байна.

Дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд нийт орны 9.5 нь хувь ногдож байгаа бөгөөд дүүргийн нэгдсэн эмнэлгийн түвшинд хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2009 онд 65.5 мянга байсан бол 2011 онд 76.7 мянга болж, 11.2 мянган хүнээр нэмэгдсэн байна.

Зураг 4.3.2. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, орны эзлэх хувь, 2011



Хүснэгт 4.3.2. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2009 он		2010 он		2011 он		Сүүлийн 3 жилийн дундаж	
	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн нэгдсэн эмнэлэг
Эмнэлгийн орны тоо	3209	1353	3189	1353	3213	1808	3204	1505
Их эмчийн тоо	863	711	894	699	903	711	887	707
Сувилагчийн тоо	1545	727	1536	747	1515	766	1532	747
Дундаж ор хоног	8.1	8.0	7.9	7.7	7.8	7.5	8.1	7.9
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	122352	65509	123750	74767	170577	76783	138893	72353
Хоног болоогүй нас баралтын хувь	30.5	29.3	30.8	29.9	34.1	29.6	31.8	29.6
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	1535327	1860310	1516156	2017029	1616455	2033432	1555979	1970257
Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	43.3	44.5	40.3	45.6	41.8	45.3	41.8	45.2
Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөд)	75.9	-	50.5	-	49.7	-	58.7	-
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)	17.2	-	15.0	-	12.0	-	14.7	-
Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн хувь	31.2	-	32.3	-	58.9	-	40.8	-

2011 онд эмнэлгийн хоног болоогүй нас баралтын эзлэх хувь аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд 2009 оноос 3.6 хувиар нэмэгдсэн байна.

Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо жилээс жилд нэмэгдэж байна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн нялхсын эндэгдлийн түвшин сүүлийн 3 жилд тогтвортой буурчээ.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 2011 онд 49.7 болж 2009 онтой харьцуулахад 26.2 пунктээр буурсан байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн хувь нэмэгдэж сүүлийн 3 жилд дунджаар 40.8 хувийг эзэлж байна.

4.4 Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн тусламж, үйлчилгээ

Бүсийн оношлогоо эмчилгээний төв нь бүс нутгийн хүн амд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагад мэргэжлийн аргачилсан зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий эрүүл мэндийн байгууллага юм.

2011 онд улсын хэмжээнд Орхон, Дорнод, Өвөрхангай, Ховд аймгуудад Бүсийн оношлогоо эмчилгээний төв ажиллаж байна.

Хүснэгт 4.4.1. БОЭТ-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд, 2009-2011

Үзүүлэлт	Онууд			Сүүлийн 3 жилийн дундаж
	2009	2010	2011	
Эмнэлгийн орны тоо	1117	1129	1145	1130.3
Дундаж ор хоног	8.3	7.8	7.5	7.9
Хоног болоогүй нас баралтын хувь	28.9	30.0	26.8	28.6
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	41820	46249	43163	43744
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	447241	454569	458211	453340
Эхийн эндэгдэл (100 000 амьд төрөлтөд)	26.8	14.2	63.7	34.9
Нялхсын эндэгдэл (1000 амьд төрсөн хүүхдэд)	10.6	21.8	15.9	16.1
Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн хувь	28.7	31.1	27.6	29.1

2009 онд БОЭТ-д 41.8 мянган хүн хэвтэн эмчлүүлж байсан бол 2011 онд 43.1 мянган хүн болж 1360 хүнээр нэмэгдсэн байна. 2010 оны байдалтай харьцуулахад хэвтэн эмчлүүлэгч 3086 хүнээр буурсан нь аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотой юм. Энэ нь шатлал алгасч ирж хэвтэгсдийн хувь буурч байгаатай хамааралтай байна. БОЭТ-д жилд дунджаар 11928 хүн сумын болон сум дундын эмнэлэг, бүсийн аймгуудаас ирж хэвтэн эмчлүүлж байгаа нь нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 27.6 хувийг эзэлжээ. БОЭТ-д хоног болоогүй нас баралтын хувь 2009 оноос 2.1 пунктээр буурсан байна.

Сүүлийн 3 жилд улсын хэмжээнд нялхсын эндэгдэл тогтвортой түвшинд байгаа хандлагын дагуу БОЭТ-ийн 1000 амьд төрсөн хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 2009 -2011 онд 1000 амьд төрөлтөд 16.1 байгаа нь улс болон аймгийн дунджаас доогуур байна.

Хүснэгт 4.4.2. БОЭТ-ийн үйл ажиллагааны зарим үзүүлэлт, 2011

Аймаг БОЭТ	Хэвтэн эмчлүүлэгчид	Ор хоног	Дундаж ор хоног	Хоног болоогүй нас баралт	Амбулаторийн үзлэг	Бүртгэгдсэн халдварт бус өвчлөл	Эхийн эндэгдэл /100000 амьд төрөлтөд/	Нялхасын эндэгдэл /1000 амьд төрсөн хүүхдэд/	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрсөн хүүхдэд/
Дорнод	10863	93810	8.6	23.2	89646	16972	52.9	17.5	21.7
Орхон	13548	93810	6.9	32.6	167484	6727	0.0	12.5	13.6
Өвөрхангай	7917	62632	7.9	34.5	82219	28241	185.9	19.2	21.1
Ховд	10835	72146	6.7	20.7	118862	25100	56.5	16.4	18.6
Дүн	43163	322398	7.5	26.8	458211	77040	63.7	15.9	18.2

2011 онд Өвөрхангай аймгийн БОЭТ-д 3, Ховд, Дорнод аймгийн БОЭТ-д тус бүр 1 эх эндсэн байна.

Хүснэгт 4.4.3. БОЭТ-ийн хүний нөөцийн зарим үзүүлэлт, 2011

№	Аймаг БОЭТ	Нийт ажиллагсад	Үүнээс			Орны тоо
			Тусгай мэргэжлийн мэргэжилтэн	Их эмч	Сувилагч	
1	Дорнод	467	212	84	150	322
2	Орхон	467	240	105	193	349
3	Өвөрхангай	284	145	68	101	216
4	Ховд	337	182	77	129	258
	Дүн	1555	779	334	573	1145

Хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын нийт ажиллагсдын 7.6 хувь нь Бүсийн оношлогоо эмчилгээний төвд ажиллаж байна.

4.5 Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүдийн тусламж, үйлчилгээ

Төв эмнэлэг нь улсын хэмжээнд төрөлжсөн мэргэжлээр эмнэлгийн тусламж үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт, судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг лавлагаа мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна.

Тусгай мэргэжлийн төв нь улсын хэмжээнд тухайн мэргэжлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэх эмчлэх хэлбэрээр үзүүлэх, лавлагаа, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэн эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллаж байна.

Нийт эмнэлгийн орны 21.1 хувь нь, мөн хэвтэн эмчлүүлэгчдийн 19.8 хувь нь УБ хотын Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүдэд ногдож байна.


Эмнэлгийн хоног болоогүй нас баралтын хувь 2011 онд 21.2 болж 2009 оноос 1.4 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 4.5.1. Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Онууд			Сүүлийн 3 жилийн дундаж
	2009	2010	2011	
Эмнэлгийн орны тоо	4005	3995	3995	3998.3
Их эмчийн тоо	1183	1207	1280	1223.3
Сувилагчийн тоо	1875	1866	1937	1892.7
Дундаж ор хоног	10.2	10.0	9.9	10.0
Хоног болоогүй нас баралтын хувь	19.8	23.5	21.2	21.5
Хэвтэн эмчлүүлэгчийн тоо	131068	135248	137929	134748.3
Амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо	1191925	1187610	1200639	1193391.3
Доод шатлалаас ирж хэвтэн эмчлүүлэгчдийн тоо /хөдөөнөөс/	30727	33622	34741	33030.0

Сүүлийн 3 жилд дунджаар Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүдэд 134 мянган хүн хэвтэн эмчлүүлж байгаагийн 25.2 хувийг хөдөөнөөс ирж хэвтэн эмчлүүлэгчид эзэлж байна. 2009 онтой харьцуулбал 2011 онд нийт хэвтэн эмчлүүлэгчид 5.3 хувиар, хөдөөнөөс ирж хэвтэн эмчлүүлэгч 13.1 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 4.5.1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хөдөө орон нутгаас ирж эмчлүүлэгчдийн эзлэх хувь, 2011



Хүснэгт 4.5.2. Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагааны зарим үзүүлэлтүүд, 2011

Эмнэлгүүдийн нэр	Амбулаторийн үзлэгийн тоо	Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид	Дундаж ор хоног	Хоног болоогүй нас баралт
Улсын клиникийн төв эмнэлэг /УКТЭ/	210449	20142	8.6	23.8
Клиникийн нэгдсэн II	79889	7110	8.8	11.9
Клиникийн нэгдсэн III	146016	15921	8.8	19.4
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	130387	36891	6.6	18.7
Хавдар судлалын үндэсний төв	85115	7515	8.9	3.3
Халдварт өвчин судлалын үндэсний төв	89277	11337	15.4	18.0
Гэмтэл согог сэргээн заслын үндэсний төв	90128	12170	13.3	29.9
Арьсны өвчин судлалын үндэсний төв	77363	5499	10.0	0.0
Сэтгэц эмгэг мансуурлын үндэсний төв	53101	5723	28.3	0.0
Нялхсын клиникийн сувилал	0	280	7.5	0.0
Уламжлалт анагаахын шинжлэх ухаан технологийн үндэсний корпораци	31179	3518	9.7	0.0
Шүүх эмнэлэг магадлах товчоо	15016	0	0.0	0.0
Герентологийн төв	8682	0	0.0	0.0

4.6 Хувийн хэвшлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ

2011 оны байдлаар 171 ортой, 1013 үүдэн хувийн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд хувийн эмнэлгүүдэд 1677 их эмч, 1619 эмнэлгийн тусгай дунд мэргэжилтэн, үүнээс 1135 сувилагч, нийт 4842 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна.


Хүснэгт 4.6.1 Хувийн хэвшлийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд

	2005	2009	2010	2011
Ортой эмнэлгийн тоо	160	160	166	171
Үүдэн эмнэлгийн тоо	523	922	947	1013
Эмнэлгийн орны тоо	1982	2422	2527	3069
Нийт оронд эзлэх хувь	10.8	13.6	14.2	16.2
Эмчийн тоо	1145	1396	1549	1677
Сувилагч	682	858	1007	1135
Амбулаторийн үзлэгийн тоо	1 016 705	1 304 897	1 036 934	1 986 901
Эмнэлэгт хэвтсэн хүний тоо	63 267	75 003	86 117	97 821
Дундаж ор хоног	9.0	8.1	7.9	8.2


Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн орны тоо 2005 онд 1982 байсан бол 2011 онд 3069 болж нэмэгдсэн бөгөөд нийт эмнэлгийн орны 16,2 хувийг эзэлж байна. 2005 оноос хувийн хэвшлийн эмнэлгүүдийг ялангуяа ортой эмнэлгийг шинээр байгуулахыг хязгаарлах, харин үйл ажиллагааны чиглэл нь улсын эмнэлгийн үзүүлж байгаа зарим эмнэлгийн тусламж үйлчилгээг хувийн хэвшлийн эмнэлгүүдээр гүйцэтгүүлэх, үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэх, төрөлжүүлэх бодлогыг хэрэгжүүлж ирсэн билээ.

Хувийн хэвшлийн эмнэлгүүдээр 2005 онд 1016705 хүн амбулаториор үйлчлүүлж, 63267 хүн хэвтэн эмчлүүлж байсан бол 2011 онд амбулаториор үйлчлүүлэгчдийн тоо 1986901, хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 97821 болж нэмэгдсэн байна. 2011 оны байдлаар хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн 37.5 хувь нь дотор, 13.2 хувь нь мэдрэл, 11.6 хувь нь уламжлалт, 10.3 хувь нь эмэгтэйчүүд, 7.8 хувь нь мэс засал, 6.5 хувь нь хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 4.6.1. Хувийн хэвшлийн оргүй эмнэлгүүд, үйлчилгээний төрлөөр, 2011



Зураг 4.6.2. Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүд, мэргэжлээр, 2011



Хувийн хэвшлийн эмнэлгүүдийг орны хүчин чадлаар ангилж авч үзвэл 5-8 ортой эмнэлэг 9.9 хувийг, 10-12 ортой эмнэлэг 40.9 хувийг, 15 ортой эмнэлэг 22.8 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд хувийн эмнэлгийн 73.7 хувь нь 15 хүртэлх ортой эмнэлгүүд байна.

Хүснэгт 4.6.2. Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн хэвтэн эмчлүүлэгчдийн хувь, 2011

Үзүүлэлт	Эмнэлгийн тоо		Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
5-8 ортой	17	9.9	3291	3.4
10-12 ортой	70	40.9	27565	28.2
15 ортой	39	22.8	19229	19.7
20-25 ортой	27	15.8	16859	17.2
30 ортой	8	4.7	7406	7.6
40-50 ортой	7	4.1	10827	11.1
50 ба түүнээс дээш ортой	3	1.8	12644	12.9
Нийт дүн	171	100	97821	100

4.7. Түргэн тусламжийн үндэсний сүлжээний төвийн алсын дуудлагын үйл ажиллагаа


Түргэн тусламжийн үйлчилгээг үр дүнтэй бүтэц, зохион байгуулалтад оруулах, менежментийг сайжруулах, техник, багаж, тоног төхөрөөмжийг шинэчлэх, боловсон хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлэх замаар олон улсын жишигт ойртсон нэгдсэн тогтолцоо бий болгох шаардлагын үүднээс “Үндэсний түргэн тусламжийн сүлжээ хөтөлбөр”-ийг 2010 оны 12 сарын 8-ны өдрийн Засгийн газрын 318 дугаар тогтоолоор баталсан билээ.


2011 оны 11 сарын 24-25-нд зохион байгуулсан “Эмнэлгийн яаралтай тусламжийн өөрчлөлт, шинэчлэлт” үндэсний чуулга уулзалт, “Газар хөдлөлтийн үеийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээ” үндэсний семинар, “Эмнэлгийн яаралтай тусламжийн өөрчлөлт, шинэчлэлт” Үндэсний чуулга уулзалтыг зохион байгуулсан.

Түргэн тусламжийн үндэсний сүлжээний төвийн алсын дуудлагын үйл ажиллагаа


2011 онд улсын хэмжээнд 242 алсын дуудлага хүлээн авч 54.9 хувьд нь орон нутагт очиж тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Зураг 4.7.1. Хүлээж авсан алсын дуудлага бодит тоогоор, 2008-2011



Зураг 4.7.2. Зонхилон тохиолдож буй дуудлага эзлэх хувиар, 2009-2011

Хөдөө орон нутгаас хүлээн авсан дуудлагын дотор осол гэмтлийн дуудлага тэргүүлэх шалтгаан болж байна.

Зураг 4.7.3. Алсын дуудлаганд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний байдал, 2008-2011


Нарийн мэргэжлийн эмч орон нутагт очиж мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлсэн дуудлагын эзлэх хувь сүүлийн 4 жилийн дунджаар 57.6 хувьтай байна. 2011онд үзүүлсэн мэс заслын тусламж үйлчилгээ сүүлийн 4 жилийн дунджаас 4.2 хувиар буурсан байна.

БҮЛЭГ 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ


Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун эргийн бүсээс гишүүн орнуудын эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бүсийн стратеги боловсруулсан билээ. Уг стратегийн хүрээнд эмч, мэргэжилтнүүдийг тэнцвэртэй хуваарилах замаар эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй хүргэнэ гэсэн зорилгыг дэвшүүлсэн байна. Манай улсад үндэсний түвшинээс эхлээд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгжүүд болох өрх, сумын эрүүл мэндийн төв, сумын дундын эмнэлгийг хамарсан эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоо хүн амд үйлчилж байна. 2009 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2010-2014 онд хөгжүүлэх” бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж байгаа билээ. Энэхүү бодлогын хүрээнд эмнэлгийн мэргэжилтнүүдийн 2020 он хүртэлх төлөвлөлтийг салбарын хэрэгцээ, бодлогыг тодорхойлсны үндсэн дээр боловсруулсан юм.

2011 оны байдлаар улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нийт 41124 ажиллагсад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Нийт ажиллагсдын 19.3 хувийг эмч, 22.9 хувийг сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжлийн мэргэжилтэн 40.1 хувийг, 17.7 хувийг бусад ажилтнууд эзэлж байгаа бөгөөд нийт ажиллагсдын 82.2 хувь нь эмэгтэйчүүд байна. 2011 оны байдлаар 10000 хүн амд 28.5 их эмч, 36.4 сувилагч/эх баригч ногдож байна. Эмч сувилагчийн (эх баригч) харьцаа улсын түвшинд 1:1.3, Улаанбаатар хотод 1:1.0, аймгийн түвшинд 1:1.7 байна.


Зураг 5.1.1. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын насны бүтэц, 2011



ДЭМБ-ын илтгэлд дурьдсанаар 10 000 хүн амд ногдох их эмчийн тоо дэлхийн дундаж 13, хөгжиж байгаа орнуудад 10, хөгжингүй орнуудад 22 байхад манай орны хувьд 28.5 байгаа нь өндөр байна. 10000 хүн амд ногдох сувилагч, эх баригчийн үзүүлэлт дэлхийн дундаж 28, хөгжиж байгаа орнуудад 15, хөгжингүй орнуудад 42 байхад Монгол улсад 36.4 байна.


Зураг 5.1.2. Дэлхийн улс орнуудын 10 000 хүн амд ногдох эмчийн нягтрал

2011 оны байдлаар хөдөө орон нутагт 10 000 хүн амд ногдох их эмчийн тоо 20.0 байгаа нь Улаанбаатар хоттой харьцуулахад 1.9 дахин бага байна. Ялангуяа аймагт Улаанбаатар хоттой харьцуулахад мэс зэслын эмч 1 дахин, дүрс оношилгоо, лабораторийн эмч 3-4 дахин, хүүхдийн эмч 1.3 дахин бага байна.

Зураг 5.1.3. 10 000 хүн амд ногдох хүүхдийн ор, хүүхдийн эмч, 2011

Дээрх үзүүлэлтээс харахад сүүлийн жилүүдэд төрөлтийн түвшин нэмэгдэж байгаа хэдий ч нийт эмнэлгийн оронд эзлэх хүүхдийн тасгийн ор болон хүүхдийн эмчийн хангалт жилээс жилд буурсаар байгааг харуулж байна.

Зураг 5.1.4. Төрийн зардлаар төгсөлтийн дараах сургалтанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, 2011



2011 онд эмч, мэргэжилтнүүдийг 3-аас дээш жил мэргэшил дээшлүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд төрийн сангийн санхүүжилтээр 300 эмч, 56 сувилагч мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, дээшлүүлэх болон богино хугацааны сургалтад хамруулсан байна. Эдгээр сургалтад нийт эмч нарын 3.8 хувь нь хамрагдсан байна.

2011 оны байдлаар Монгол улсад эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэдэг улс, хувийн хэвшлийн 10 сургуулийг 2700 гаруй оюутан төгссөн байна.

2010-2011 онд эрүүл мэндийн салбарт хийгдсэн зарим судалгааны ажлууд

Эрүүл мэндийн салбарт жил бүр олон судалгаа шинжилгээний ажлууд хийгдэж улмаар бодлого боловсруулагчид болон шийдвэр гаргагчдад нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах болон эмчилгээ оношлогоо, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад томоохон хувь нэмэр болж байгааг дурдахад таатай байна. Цаашдаа эрүүл мэндийн салбарт хийгдэж байгаа эрдэм шинжилгээ судалгааны ажлууд болон үнэлгээг бүх шатандаа өргөн ашиглаж хоорондын хамтын ажиллагааны уялдаа холбоо өргөжин тэлэх үүднээс зарим судалгааны ажлын нэрсийг толилуулж байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийн талаар:

- ❖ “Хүүхэд хөгжил -2010” үндэсний суурь судалгаа
- ❖ “Жирэмсэн үеийн чихрийн шижинг эрт илрүүлэх нь” - 2010 он
- ❖ “Умайн артерийн доплер шинжилгээг жирэмсэн эхчүүдэд хийсэн үзүүлэлт” - 2010 он
- ❖ “Нярайн цусан дах чихэр багадалтыг эрт илрүүлэх” - 2010 он
- ❖ НҮБ-ын Хүн амын сангийн “Улс хөгжүүлэх 5 дахь хөтөлбөр (2012-2016 он)”-ийн суурь үнэлгээ. 2011 он
- ❖ Хүүхдийн дүрс оношлогооны нийгэмлэг ба Мэс засалчдын багийн дэмжлэгтэй хэрэгжиж буй “Нярайн түнхний үений дисплази, мултралын хэт авиан скрининг оношлогоо” (2011 он).
- ❖ АНУ-ын Харвардын их сургуулийн “Эмэгтэйчүүдийн жирэмсэн ба жирэмсэн бус үеийн судасны эсэргүүцлийг судасны тонометрээр тодорхойлох судалгаа” (2011 он) сэдэвт хамтарсан судалгаа
- ❖ “Монгол улсын эхийн эндэгдлийн өнөөгийн байдал” 2011 он
- ❖ “Эхийн ноцтой хүндрэл, тулгамдаж буй асуудал” 2011 он
- ❖ “Эрт нярай үеийн эндэгдэл, өнөөгийн байдал” 2011 он

Халдварт бус өвчлөлийн чиглэлээр:

- ❖ Замын аюултай цэгүүдийг тодорхойлох судалгаа
- ❖ Байгууллагад суурилсан үр нөлөөг үнэлэх судалгаа
- ❖ Зам тээврийн осол, хэргийн шинж байдал ба шалтгаан
- ❖ Халдварт бус өвчний талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадал”-ын судалгаа
- ❖ Явган зорчигч, жолооч, замын цагдаа нарын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэдлэг, хандлага, дадлын судалгаа
- ❖ Умайн хүзүүний хавдрыг эрт илрүүлэх, эрүүл мэндийн тусламж хайх зан үйлийн судалгаа
- ❖ Эмэгтэйчүүдийн хөхний хавдартай холбоотой эрүүл мэндийн тусламж хайх зан үйлийн судалгаа
- ❖ “Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын ХБӨ–ний талаарх мэдлэг, дадал, хандлагыг тодорхойлсон судалгаа
- ❖ Үргүйдэлд үзүүлж буй тусламжийн өнөөгийн байдал /суурь үнэлгээ/
- ❖ Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эрүүл мэндийн зан үйлийг тодорхойлох судалгаа

БҮЛЭГ 6. ХАЛДВАРТ ӨВЧИН

6.1. Нийт халдварт өвчин


2011 онд улсын хэмжээнд 31 төрлийн цочмог халдварт өвчний 42839 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 1466 тохиолдлоор нэмэгдсэн буюу 10000 хүн амд 154.1 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.9-өөр нэмэгдсэн байна. 21 аймаг, Улаанбаатар хотод бүртгэгдсэн цочмог халдварт өвчний 10 000 хүн ам тутамд ногдох өвчлөлийг өмнөх онтой харьцуулахад Архангай, Булган, Говьсүмбэр, Дархан-уул, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий аймагт нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2011 онд вирүст хепатит, салхин цэцэг, гахай хавдар, улаан эсэргэнэ, ёлом, улаанууд, хачигт рикеттиоз, тэмбүү, зэрэг өвчнүүд өмнөх онтой харьцуулахад 10 000 хүн амд 0.1-19.5 тохиолдлоор нэмэгдсэн нь халдварт өвчний өсөлтөнд нөлөөлсөн байна.

2011 онд бүртгэгдсэн цочмог халдварт өвчин Дорнод, Баянхонгор, Говь-Сүмбэр, Дорноговь, Өмнөговь, Хэнтий, Булган, Улаанбаатар хотод улсын дунджаас /10 000 хүн амд 154.1/ өндөр байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт өвчлөлийн 46.6 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

2011 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт халдварт өвчнүүдийн 31.4 хувийг бэлгийн замаар дамжих халдвар, 34.3 хувийг вирүст хепатит, 9.3 хувийг сүрьеэ, 6.0 хувийг гэдэсний халдварт өвчнүүд, 9.2 хувийг амьсгалын замын халдвар, 9.8 хувийг бусад халдвар тус тус эзэлж байна.

Зураг 6.1.1. 2011 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн халдварт өвчний бүтэц



6.2. Гэдэсний халдвар

2011 онд улсын хэмжээнд вирүст хепатит А, цусан суулга, хүнсний гаралтай бактерт хордлого, сальмонеллын халдвар, балнад, суулгалт халдвар, гар хөл амны өвчин зэрэг 7 төрлийн гэдэсний халдварт өвчний 17247 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 40.3 хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэдэсний халдварт өвчний 6733 (39%) нь Улаанбаатар хотод гарсан байна.

Гэдэсний замын халдварт өвчний 78.9 хувийг вирүст хепатит А, 12.3 хувийг цусан суулга, 6.0 хувийг гар хөл амны өвчин, 1.6 хувийг хүнсний гаралтай бактерт хордлого тус тус эзэлж байна.

Хүснэгт 6.2.1. Гэдэсний халдварт өвчнүүдийн тохиолдлын тоо, 10 000 хүн амд

Халдварт өвчин /ӨУА-10 нэршлээр/	2010		2011		Өсөлт /бууралт/ 10 000 хүн амд
	Бодит тоо	10 000 хүн амд	Бодит тоо	10 000 хүн амд	
Балнад	1	0.0	2	0.0	0.0
Сальмонеллөз	146	0.5	118	0.4	-0.1
Цусан суулга	3451	12.6	2120	7.6	-5.0
Хүнснээс гаралтай бактерт хордлого	510	1.9	278	1.0	-0.9
Суулгалт халдвар	84	0.3	75	0.3	0.0
Вирүст хепатит А	8116	29.7	13612	49.0	19.3
Гар-хөл-амны өвчин	2585	9.4	1042	3.7	-5.7

6.2.1. Вирүст хепатит

Улсын хэмжээнд вирүст хепатит өвчний 14672 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 34.3 хувийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 5573 тохиолдлоор нэмэгдсэн байна. Нийт вирүст хепатитийн өвчлөлийн 92.7 хувийг вирүст хепатит А, 5.1 хувийг вирүст хепатит В, 1.0 хувийг вирүст хепатит С, 1.2 хувийг бусад вирүст хепатит тус тус эзэлж байна.



Улсын хэмжээнд бүртгэгдсэн А вирүст хепатитийн өвчлөлийг насны байдлаар авч үзэхэд, бүх насанд өвчлөл бүртгэгдсэн боловч 2-9 насанд хамгийн өндөр бүртгэгдэж, нийт өвчлөлийн 86.1 хувийг 0-15 насны хүүхдийн өвчлөл эзэлж байна.

Улсын хэмжээнд 2011 онд бүртгэгдсэн А вирүст хепатитийг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүдийн дунд өвчлөл илүү бүртгэгдэж 54.2 хувийг эзэлж байна.

А вирүст хепатитийн өвчлөлийг нийгмийн байдлаар авч үзэхэд, сургуулийн сурагч, цэцэрлэгт явдаг болон гэртээ байдаг хүүхдүүдийн дунд өвчлөл өндөр бүртгэгдсэн байна. Нийт өвчлөлийн 66.7 хувийг сургууль, цэцэрлэг, яслийн хүүхдийн өвчлөл эзэлж байна.

Хүснэгт 6.2.2. Вирүст хепатитийн өвчлөл, 10 000 хүн амд /улсын дунджаас дээгүүр байгаа аймгуудаар, 2011/

Аймаг	2010		2011		Өсөлт /бууралт/ 10 000 хүн амд
	Бодит тоо	10 000 хүн амд	Бодит тоо	10 000 хүн амд	
Дорнод	288	39.1	1020	138.6	99.5
Увс	212	26.9	815	104.2	77.3
Булган	127	20.4	488	77.9	57.5
Дундговь	95	19.9	348	75.1	55.2
Орхон	314	37.8	610	71.1	33.3
Өвөрхангай	372	31.7	715	60.9	29.2
Дорноговь	272	46.6	349	58.6	12.0
Архангай	303	32.8	529	57.7	24.9
Ховд	102	11.5	478	54.1	42.6
Улсын дундаж	9099	33.3	14672	52.8	19.5

Зураг 6.2.1. Вирус хепатитийн өвчлөл, нас баралт, хандлага, 2001-2011**Зураг 6.2.2. Вирус хепатитийн өвчлөл, бодит тоо, улирлаар, 2011**

2011 онд бүртгэгдсэн вирус хепатитийн өвчлөлийг улиралчилсан байдлаар авч үзэхэд 9, 10, 11 саруудад огцом өсч нийт өвчлөлийн дийлэнхи хувь нь тухайн сард дэгдэлт хэлбэрээр бүртгэгджээ.

6.3. Амьсгалын замын цочмог халдвар

Амьсгалын замын зарим цочмог халдварт өвчний 8202 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 19.1 хувийг эзэлж байна.

Нийт өвчний дотор сүрьеэ (48.6%), салхинцэцэг (37.8%), гахай хавдар (12.4%) -ын халдвар зонхилох хувийг эзэлж байна. 2010 онтой харьцуулахад сүрьеэ 228, менингококкт халдвар 8 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

10 000 хүн амд ногдох салхин цэцэг 6.5, гахай хавдар 1.8, улаан эсэргэнэ 0.1, улаанууд 0.1 тохиолдлоор өнгөрсөн оны мөн үеэс нэмэгдсэн байна.

Хүснэгт 6.3.1. Амьсгалын замын цочмог халдварт өвчнүүдийн тохиолдлын тоо, 10 000 хүн амд

Халдварт өвчин /ӨОУА-10 нэршлээр/	2010		2011		Өсөлт /бууралт/ 10 000 хүн амд
	Бодит тоо	10 000 хүн амд	Бодит тоо	10 000 хүн амд	
Сүрьеэ	4213	15.4	3985	14.3	-1.1
Улаан эсэргэнэ	21	0.1	68	0.2	0.1
Менингококкт халдвар	28	0.1	20	0.1	0.0
Салхин цэцэг	1268	4.6	3097	11.1	6.5
Улаанбурхан	0	0.0	0	0.0	0.0
Улаанууд	11	0.0	16	0.1	0.1
Гахай хавдар	524	1.9	1016	3.7	1.8

6.3.1. Сүрьеэ

Сүрьеэ өвчний нийт 3985 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 9.3 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод өвчлөлийн 2268 тохиолдол байгаа нь сүрьеэгийн нийт өвчлөлийн 56.9 хувийг эзэлж байна.

Уушгины түрхэц эерэг шинэ сүрьеэ 1723 бүртгэгдсэн нь урьд онтой харьцуулахад 114 тохиолдлоор буурсан байна.

Шинээр бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын 74.5 хувийг уушгины сүрьеэ, 25.5 хувийг бусад эрхтний сүрьеэ эзэлж, хүүхдийн сүрьеэ 380 тохиолдол илэрсэн ба энэ нь сүрьеэгийн нийт шинэ тохиолдлын дотор 9.5 хувийг эзэлж байна.


Хүснэгт 6.3.2. Сүрьеэгийн өвчлөл, 10 000 хүн амд /улсын дунджаас дээгүүр байгаа аймгуудаар, 2011/

Аймаг	2010		2011		Өсөлт /бууралт/ 10 000 хүн амд
	Бодит тоо	10 000 хүн амд	Бодит тоо	10 000 хүн амд	
Дархан-Уул	241	26.8	214	23.3	-3.5
Сэлэнгэ	251	24.3	247	23.2	-1.1
Дорнод	155	21.1	144	19.6	-1.5
Сүхбаатар	97	17.7	99	18	0.3
Дорноговь	88	15.1	97	16.3	1.2
Улсын дундаж	4213	15.4	3985	14.3	-1.1


Шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдлыг насаар нь авч үзвэл:

16-44 насныхан 69.0 хувь байгаа нь залуу хөдөлмөрийн насны хүмүүс илүүтэй өвчилж байна. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд 56.0 хувь, эмэгтэйчүүд 44.0 хувь, хүйсийн харьцаа (эр: эм) = 1.2:1.0 байна.

Зураг 6.3.1. Сүрьеэгийн өвчлөл, нас баралтын хандлага, 2001-2011



Зураг 6.3.2. Сүрьеэгийн оношийн баталгаажилт хувиар, 2011



2011 оны байдлаар оношийн баталгаажилт 74.1 хувь, эдгэрэлтийн түвшин 83.1 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад оношийн баталгаажилт 0.7 хувиар, эдгэрэлтийн түвшин 1.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Гахай хавдрын өвчлөл


Улсын хэмжээнд гахай хавдар өвчний 1016 тохиолдол буюу 10000 хүн амд 3.7 бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 492 тохиолдлоор буюу 10000 хүн амд 1.8-аар нэмэгдэж дэгдэлт болсон байна. 10000 хүн амд ногдох өвчлөл Өмнөговь /72.9/, Баянхонгор /9.9/, Дорнод /5.0/, Увс /1.9/, Хэнтий /1.4/, Говьсүмбэр /0.7/, Төв /0.6/, Архангай /0.5/, Завхан /0.3/, Улаанбаатар хотод /4.1/ өмнөх онтой харьцуулахад /0.1-72.9/-өөр ихэссэн байна.

Нийт өвчлөлийн 36.6 хувийг нь Өмнөговь аймагт бүртгэгдсэн өвчлөл эзэлж байгаа ба тус аймгийн Гурвантэс сумын ерөнхий боловсролын дунд сургуулийн дотуур байрны хүүхдүүдийн дунд гахай хавдар өвчин дэгдэлт хэлбэрээр бүртгэгдсэн ба гахай хавдрын вирусн F генотипээр үүсгэгдсэн болохыг тодорхойлсон байна.

2011 онд бүртгэгдсэн гахай хавдарын 223 тохиолдол буюу 48 хувийг сургуулийн насны хүүхдийн өвчлөл эзэлж байна.


Өвчлөлийн дотор 40.9 хувийг 5-9 насны, 22.3 хувийг 10-14 насны, 10.7 хувийг 15-19 насны, 7.9 хувийг 5 хүртэлх насны хүмүүс тус тус эзэлжээ.

Зураг 6.3.3. Гахай хавдар өвчний хөдлөл зүй, 10 000 хүн амд /1996-2011/



Улсын хэмжээнд 1996-2011 онуудад бүртгэгдсэн гахай хавдрын өвчлөлийн хөдлөл зүйгээс харахад 3-4 жилийн давтамж ажиглагдаж байна.

Гахай хавдрын улиралчлалыг авч үзэхэд 3-6 сард өвчлөл нэмэгдсэн байна. Харин өмнөх онд халдварын улиралчлал 5 сард нэмэгджээ. /Зураг 6.3.4./

Зураг 6.3.4. Гахай хавдрын өвчлөл, бодит тоо, улирлаар, 2011**Салхинцэцгийн өвчлөл**

Энэ онд салхинцэцгийн нийт 3097 тохиолдол буюу 10 000 хүн амд 11.1 тохиолдол бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулахад 6.5-аар, 5 жилийн дундажтай харьцуулахад 1.6-аар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2011 онд Баян-Өлгий аймагт салхинцэцгийн тохиолдол бүртгэгдээгүй. Өмнөговь /24.3/, Дорноговь /18.0/, Дундговь /18.4/, Өвөрхангай /18.1/, Хэнтий /14.9/, Баянхонгор /10.7/, аймаг, Улаанбаатар хотод /15.1/ салхинцэцгийн өвчлөл хамгийн өндөр байгаа ба өмнөх 5 жилийн дундаж /9.5/-аас дээгүүр байна. Салхинцэцгийн өвчлөлийг өмнөх онтой харьцуулахад Булган, Завхан, Сүхбаатар аймгуудад 0.4-2.9 промилль-оор тус тус буурсан, бусад аймаг, Улаанбаатар хотод 0.4-22.9 промилль-оор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Өвчлөлийн 59.8 хувь нь 0-9 насны хүүхдийн өвчлөл эзэлж үүний дотор 68.0 хувийг 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл эзэлж байна.

6.4 Бэлгийн замаар дамжих халдвар

Бэлгийн замаар дамжих халдварын 13427 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний дотор 31.3 хувийг эзэлж, өнгөрсөн онтой харьцуулахад 874 тохиолдол буюу 6.5 хувиар буурсан байна. Нийт бүртгэгдсэн өвчлөлийн 29.8 хувийг трихомониаз, 38.4 хувийг заг хүйтэн, 31.8 хувийг тэмбүү тус тус эзэлж байна.

Хүснэгт 6.4.1. Бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлын тоо, 10 000 хүн амд


Халдварт өвчин /ӨОУА-10 нэршлээр/	2010		2011		Өсөлт /бууралт/ 10 000 хүн амд
	Бодит тоо	10 000 хүн амд	Бодит тоо	10 000 хүн амд	
Тэмбүү	3937	14.4	4268	15.3	0.9
Заг хүйтэн	5741	21.0	5159	18.6	-2.4
Трихомониаз	4623	16.9	4000	14.4	-2.5

10 000 хүн амд ногдох тэмбүүгийн өвчлөл Говьсүмбэр, Дорнод, Дорноговь, Баянхонгор, Хэнтий, Дархан-уул, Сүхбаатар, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Хөвсгөл аймгууд болон Улаанбаатар хотод, заг хүйтэн Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Говь-Алтай, Хөвсгөл, Баянхонгор, Сүхбаатар, Хэнтий аймгуудад, трихомониазын өвчлөл Булган, Баянхонгор, Дорнод, Дорноговь, Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Сүхбаатар, Завхан аймгууд болон Улаанбаатар хотод улс болон аймгийн дунджаас өндөр байна.

2011 онд төрөлхийн тэмбүүгийн 15 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 4 тохиолдлоор нэмэгдсэн байна. Төрөлхийн тэмбүүгийн өвчлөл Дорнод, Өмнөговь, Төв, Увс аймгуудад тус бүр 1, Баянхонгор, Орхон, Хөвсгөл аймгуудад тус бүр 2, Улаанбаатар хотод 5 тохиолдол бүртгэгдсэн байна.

2011 онд жирэмсэн эмэгтэйчүүдэд хийсэн 76826 үзлэгийн дүнгээс үзвэл тэмбүү 1867 (2.5%), заг хүйтэн 589 (0.9%), трихомониаз 1495 (2.1%) тус тус илэрсэн байна.

Зураг 6.4.1. Зонхилон тохиолдох бэлгийн замын халдварт өвчин, 10 000 хүн амд, 2009-2011



БЗДХ-аар өвчлөгсдийн 37.6 хувь нь эрэгтэй, 62.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт өвчлөгсдийн нийгмийн байдлыг авч үзвэл 32.7 хувь ажил эрхэлдэг, 50.9 хувь ажил эрхэлдэггүй, 13.8 хувь оюутан, 0.5 хувь цэргийн албан хаагчид, 0.8 хувь 0-15 насны хүүхэд байна.

Насны ангиллаар авч үзэхэд 0.25 хувь 0-4 насны, 0.56 хувь 5-14 насны, 40.3 хувь 15-24 насны, 54.4 хувь 25-44 насны, 4.2 хувь 45-64 насны, 0.2 хувь 65-аас дээш насны хүмүүс байна.

ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн 14 (82.3%) эрэгтэй, 3 (17.6%) эмэгтэй байна. 2010 онд ХДХВ-ийн халдвартай бүртгэгдсэн тохиолдлууд 100% бэлгийн замаар халдвар авсан. ХДХВ-ийн халдварын 3 (17.6%) тохиолдол идэвхитэй тандалтаар, 14 (82.3%) тохиолдол нь янз бүрийн өвчний улмаас эмнэлэгт хандсан болон хэвтэн эмчлүүлж байсан хүмүүсээс илэрсэн байна.

Халдварт өвчний шалтгаант нас баралтын 150 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 45 тохиолдлоор буурсан байна. Нийт нас баралтын тохиолдлыг шалтгаанаар авч үзвэл сүрьеэ -111, вирүст хепатит-20, боом - 6, менингококкт халдвар-3, төрөлхийн тэмбүү өвчнөөр-4, ХДХВ/ДОХ-ын халдвараар - 2, салхин цэцэг, ёлом, хачигт рикеттиоз болон галзуу өвчний улмаас тус тус 1 хүн нас барсан байна.

БҮЛЭГ 7. ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛ


7.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан

Дэлхий нийтээрээ Халдварт бус өвчнийг хянах талаар анхаарлаа хандуулж “Эрүүл аж төрөх ёс, Халдварт бус өвчний хяналт” сэдвээр ОХУ-ын Москва хотноо Дэлхийн сайд нарын анхдугаар чуулга уулзалт болов. НҮБ, ДЭМБ-аас 2011 оныг Халдварт бус өвчинтэй тэмцэх жил болгон олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсээр байна.

Мөн 2011 онд “Халдварт бус өвчин, осол гэмтлийн сэргийлэлт ба хяналт” сэдэвт үндэсний чуулган төрийн ордонд чуулав.

Монгол улсын 15-64 насны хүн амын халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдлэг хангалтгүй байдгаас өөрсдийн эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс сэргийлэх эерэг хандлага бүрдээгүй байна. Ялангуяа эрэгтэйчүүд, залуу насныханд зан үйл, өөрийн хяналт, өвчлөх эрсдлийн талаарх мэдлэг дутмаг, зөв үзэл бодол төлөвшөөгүй байна.

Зураг 7.1.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд /2001-2011/



2011 оны байдлаар 10000 хүн амд амьсгалын тогтолцооны өвчин 1048.17, хоол боловсруулах тогтолцооны өвчин 953.17, шээс бэлгийн тогтолцооны өвчин 766.37, зүрх-судасны тогтолцооны өвчин 752.07, гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчин 491.75 ногдож байгаа бөгөөд 2010 онтой харьцуулахад амьсгалын тогтолцооны өвчин буурсан байна. Хоол шингээх, шээс бэлгийн, зүрх-судасны тогтолцооны өвчин болон гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчлөлийн түвшин буураагүй нэмэгдсэн хэвээр байна. (Зураг 7.1.1)

2011 оны байдлаар хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд:

- Амьсгалын тогтолцооны өвчин /10 000 хүн амд 1048.17/
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин /10 000 хүн амд 953.17/
- Шээс бэлгийн тогтолцооны өвчин /10 000 хүн амд 766.37/
- Зүрх-судасны тогтолцооны өвчин /10 000 хүн амд 752.07/
- Гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчин /10 000 хүн амд 491.75/ орж байна.

2011 онд хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгааныг байршлаар авч үзвэл УБ хотод амьсгалын тогтолцооны өвчин, хоол боловсруулах өвчин, гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчин, хөдөөд амьсгал, хоол боловсруулах, шээс бэлгийн тогтолцооны өвчин тэргүүлэх 3 шалтгаанд орж байна. Тухайлбал 10000 хүн амд ногдох амьсгалын тогтолцооны өвчин хотод 842.06, хөдөөд 1219.74, хоол боловсруулах тогтолцооны өвчин хотод 811.84, хөдөөд 1070.82, шээс бэлгийн тогтолцооны өвчин хотод 624.91, хөдөөд 884.12, осол гэмтлийн шалтгаант өвчлөл хотод 782.33, хөдөөд 249.86, зүрх-судасны тогтолцооны өвчин хотод 646.90, хөдөөд 839.70 ногдож байна.

Хүснэгт 7.1.1. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, нас, хүйсээр, 2011

	Нийт өвчлөл	Амьсгалын тогтолцооны өвчин	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	Зүрх-судасны тогтолцооны өвчин	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг
Хүйс						
Эрэгтэй	4851.68	1004.32	778.24	352.60	588.70	642.87
Эмэгтэй	7450.63	1089.65	1118.64	1157.77	906.60	348.80
Насны бүлэг						
20 хүртэл	4639.27	1942.20	747.44	215.90	46.14	372.41
20-44	5649.10	419.68	811.42	1035.87	404.11	573.00
45-65	9223.96	663.11	1567.64	1172.11	2239.97	536.55
65 ба түүнээс дээш	13514.69	1128.29	1847.64	1155.10	5091.41	452.30
Байршил						
Хот	6151.20	842.06	811.84	624.91	646.90	782.33
Хөдөө	6217.24	1219.74	1070.82	884.12	839.70	249.86
Бүсээр						
Баруун	5887.00	1181.31	873.01	994.67	834.30	167.47
Хангайн	6221.13	1064.86	1121.14	930.79	938.60	222.80
Төв	6393.19	1340.34	1042.78	842.51	829.20	324.82
Зүүн	6408.89	1432.76	1374.31	644.55	599.60	300.67
Улсын дүн	6187.24	1048.17	953.17	766.37	752.10	491.75

10 000 эмэгтэй хүн амд ногдох амбулаторт бүртгэгдсэн өвчлөлийн түвшин эрэгтэй хүн амтай харьцуулахад 1.6 дахин их байна. Өвчлөлийн шалтгаанаар авч үзвэл эрэгтэйчүүд гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэгийн улмаас амбулаторит үзүүлж, эмчлүүлсэн өвчлөлийн түвшин эмэгтэйчүүдтэй харьцуулахад 1.8 дахин их, бусад өвчлөлийн тэргүүлэх шалтгааны хувьд өвчлөлийн түвшин 1.1-3.3 дахин бага байна.

Хүн амын өвчлөлийг бүс нутгаар авч үзвэл баруун бүсэд амьсгалын тогтолцооны өвчин (1181.3), шээс бэлгийн тогтолцооны өвчин (994.67), хоол боловсруулах тогтолцооны өвчин (873.01), хангайн бүсэд амьсгалын тогтолцооны өвчин (1064.86), хоол боловсруулах тогтолцооны өвчин (1121.14), шээс бэлгийн тогтолцооны өвчин (930.79), төвийн болон зүүн бүсэд амьсгалын тогтолцооны өвчин (1340.34 ба 1432.76), хоол боловсруулах тогтолцооны өвчин (1042.78 ба 1374.31), шээс бэлгийн тогтолцооны өвчин (842.51 ба 644.55) тэргүүлэх 3 шалтгаанд орж байна.

Түүнчлэн амьсгалын тогтолцооны өвчин төвийн болон зүүн бүсэд, хоол боловсруулах тогтолцооны өвчин төвийн болон зүүн бүсэд, шээс бэлгийн тогтолцооны өвчин баруун

